




# СОЁМЬО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.03.26 №12 (10689)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

## "ОЛОН УЛСЫН ЦЭРГИЙН НААДАМ-2020"-ЫН ЦАХИМ БАГА ХУРАЛ БОЛОВ



Олон улсын "Цэргийн наадам-2020"-ыг зохион байгуулах тухай асуудлыг хэлэлцэх цахим бага хурал боллоо. Монгол Улсын талаас ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ, УХМАБХ-ийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа М.Батхуяг, АУГ-ын мэргэжилтэн, дэд хурандаа У.Ундрах, БСТГ-ын мэргэжилтэн, дэд хурандаа Л.Давааням нар оролцсон бөгөөд ОХУ, БНХАУ, Энэтхэг, Беларусь, Казахстан, Узбекистан, Иран, Шри Ланк улсын Зэвсэгт хүчний төлөөлөгчид хуралдлаа. Цахим бага хурлын үеэр оролцогч талууд өөрсдийн нутаг дэвсгэрт зохиогдох тэмцээн, уралдаан болон түүнд оролцсон өөрчлөлтийн талаар мэдээлэл өгч, санал солилцсон юм. Үүний дараа ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар "Аравт-2020" морин цэргийн уралдааны талаар мэдээлэл өгөв. Тодруулбал,

оролцогч улсын хувьд адуугаа уралдаан явагдах газар орон хүртэл тээвэрлэх зардлыг өөрөө хариуцах, Монголын талаас адууг хил, гаалиар нэвтрүүлэх журмыг хөнгөвчлөх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа болон уралдааны ялагчийг маршрутыг туулсан нийт хугацаагаар нь тодруулах, хугацаа ижил байх тохиолдолд нэгдүгээр шатны дүнг харгалзах талаар мэдээлсэн. ОХУ-ын талаас "Танкийн биатлон" тэмцээнд оруулж буй өөрчлөлтийн талаар мэдээлэхдээ "Оролцогч улсуудад хоёр хувилбар санал болгож байгаа бөгөөд эхний хувилбараар буудлагын журмыг хүндрүүлж байны тоог тав хүртэл нэмэгдүүлэн, багууд явдал дунд хоёр, зогсолтоос гурван байг буудаж устгах бөгөөд оноогүй байны тоогоор торгуулийн тойрог оногдуулна. Сүүлийн хувилбараар байны тоог гурав болгож, гал нээх явцад оноогүй бай үлдвэл байны тоогоор галт хэрэглэл нэмж

буудлага хийлгүүлж, оноогүй байны тоогоор нь торгуулийн тойрог оногдуулах санал оруулсан" гэв. Улмаар энэ тэмцээнд оролцогч бүх талаас санал авахад есөн улсаас БНХАУ, Беларусийн тал нэгдүгээр хувилбарыг дэмжиж, бусад улс хоёрдугаар хувилбарыг сонгосон юм. Түүнчлэн тус тэмцээнд зөвхөн "Т-90" танк ашиглана гэж мэдээлсэн. Мөн "Цэргийн наадам-2020"-д оролцогч орнуудын соёлын нэгдсэн наадмыг 2020 оны 8 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд Алабинод зохион байгуулах болсноо мэдэгдэв. Тус арга хэмжээний үеэр үзэсгэлэн дэглэж, гар урлалын бүтээл, үндэсний хувцас, тоглоом наадмыг сонирхуулах аж. Хурлын төгсгөлд ОХУ-ын талаас оролцогч бүх улсын Батлан хамгаалахын атташе нарыг 3 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч уулзан тэмцээн, уралдаантай холбоотой баримт бичгийг өгч, дараагийн цахим хурлын товгыг хэлэлцэхээр болсныг зарлав.

## ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ БОЛЛОО



ЗХЖШ-ын Ар талын газрын Зэвсэглэлийн хэлтэс 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнийхөө дагуу "Зэвсгийн мэргэжилтнүүдийн өдөр"-ийг тохиолдуулан "Зэвсгийн мэргэжилтнүүдийн холбоо"-той хамтран "Зэвсэглэлд сайжруулалт хийх арга зам, зэвсэг, галт хэрэглэлийн хангалт-2020" сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгууллаа. Хуралд Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар болон бусад зочид оролцсон юм.

Тус хурлаар техникийн ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хурандаа Т.Намсрай "Монгол Улсын Зэвсэгт хүчний пуужинт артиллерийн зэвсэглэлийг шинэчлэх зарим хандлага, төсөөлөл", ҮБХИС-ийн докторант, бригадын генерал Д.Баярсайхан "Пуужинт артиллерийн зэвсэглэлийн тулгамдсан зарим асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам", цэргийн ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хурандаа А.Хүү-Ухна "Цэргийн зэвсэг, галт хэрэглэлийн байлдааны чадварыг үнэлэх аргачлал" сэдвээр илтгэл тавьсан бөгөөд нийт 10 илтгэлийг хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцав.

Ахмад Б.ГАНТУЛГА

## ХУРАНДАА ЦОЛ ОЛГОВ



"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 99 жилийн ойг тохиолдуулан ЗХЖШ-ын даргын тушаалаар эрхэлсэн албандаа идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дэд хурандаа нарт хурандаа цол олголоо. БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Батлан хамгаалахын хэмжил зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ерөнхий хэмжил зүйч, дэд хурандаа З.Бадралт, ҮБХИС-ийн БХУА-ийн Цэргийн удирдлагын төвийн ахлах багш, дэд хурандаа Ц.Батгэрэл, Цэргийн төв эмнэлгийн эмнэл зүй эрхэлсэн орлогч, дэд хурандаа Р.Баянмөнх, ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсийн хүний нөөцийн нөхөн хангалтын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Л.Дагвасүрэн, Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн захирагч, дэд

хурандаа Ц.Амарсайхан нарын зарим алба хаагчдад хурандаа цол олгосон юм. Еслолын ажиллагаанд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар, орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар тэргүүтэй удирдлагууд оролцож шинэхэн хурандаа нарт баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсэв.

Мөн Нийслэлийн Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, хошууч Э.Амарбатад дэд хурандаа, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн математик, мэдээллийн технологийн тэнхимийн дарга, ахмад В.Бат-Эрдэнэд хошууч, БХЯ-ны Барилга захиалагчийн албаны хяналтын инженер, ахлах дэслэгч Д.Доржханд нарын алба хаагчдад ахмад цолыг тус тус олголоо.

## ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ХАНДИВЫН ЦУВАА ҮРГЭЛЖИЛСЭЭР..

Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад явагдаж буй Умард атлантын гэрээний байгууллага (НАТО)-ын цэргийн хүчний тэргүүлсэн "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж буй дэд хурандаа Э.Билэгсайхан захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний XI ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний сэтгэлийн дэмээр бүрдсэн мөнгөн хандивыг ЗХЖШ-ын ЭДЦХАХ-ийн дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ар гэрийн төлөөллийн хамтаар ЭМЯ-ны ТЗУГ-ын дарга Б.Цогтбаатарт хүлээлгэн өгч, ил захидлыг нь уншиж танилцуулав.

Захидалд "Дэлхий нийтээр тархаад буй "СО-VID-19" вирусийн тархалттай тэмцэхэд сэтгэлийн дэм өгөх үүднээс ард түмнийхээ эрүүл энхийн төлөө манай цэргийн багийн бие бүрэлдэхүүний санаачилгаар 1,2 сая төгрөгийг хандив болгон далайд дусал нэмэр хэмээн өргөж байна. Аюулт халдварт өвчний эсрэг, эх орон, ард түмнийхээ төлөө оюун ухаан, бие сэтгэл, хүч чадлаа дайчлан ажиллаж буй та бүхэнд цэргийн багийн нийт бие бүрэлдэхүүний нэрийн өмнөөс амжилт бүхний дээдийг хүсье" гэжээ.



Мөн энэ үеэр ЭМЯ-ны ТЗУГ-ын дарга Б.Цогтбаатар "Хүнд цаг үед эх орон, ард түмнээ гэсэн халуун сэтгэлээр тусламжийн гараа сунгаж буй энхийг сахиулагчдадаа талархаж байна" гэдгээ илэрхийлээд дэд хурандаа Э.Билэгсайхан захирагчтай цэргийн багийн бие бүрэлдэхүүнд хаягласан талархлын бичгийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлийн өмнөөс хурандаа Б.Бат-Эрдэнэд гардуулсан юм.

Манай сурвалжлагч хилийн чанадаас мэдээлж байна

## "МАРШ"-ИЙН МАНЛАЙЛАГЧИД ТОДОРЛОО

"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 99 жилийн ойг тохиолдуулан цэргийн багийн бие бүрэлдэхүүний дунд "Марш-тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн"-ийг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн нэрэмжит болгон зохион байгууллаа. Тэмцээний нээлтийн үеэр батальоны захирагчийн орлогч, штабын дарга, хурандаа Ц.Буянжаргал хэлсэн үгэндээ "Жил бүр Их жанжин Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөр жанжнаараа овоглосон ҮБХИС-ийн нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах цэрэгжлийн

гимнастикийн тэмцээнийг зохион байгуулдаг уламжлалтай. Энэхүү уламжлалыг хадгалж, цэргийн багийн "Марш-тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн"-ийг ҮБХИС-ийн нэрэмжит болгон зохион байгуулж байна. Цаг хугацааны хувьд ажиллагааны газар орны нөхцөл шалдал, уламжлалт Сар шинийн баяр зэргээс бэлтгэлтэн хойшилсон ч Зэвсэгт хүчний 99 жилийн түүхт ойг тохиолдуулан зохион байгуулж байгаадаа баяртай байна" хэмээн онцолсон юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)



## УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ТОГТМОЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Дэлхий нийтээр тархаад байгаа цар тахал буюу коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэ талаар Хуурай замын цэргийн командлалын Материал техникийн хэлтсийн эрүүл ахуйч, эмч, дэд хурандаа Д.Алтантуул

хэлэхдээ "Командлалын байранд ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр бүр тогтмол хийж, бие бүрэлдэхүүний халууныг өглөө бүр хэмжин нэвтрүүлж байна. Мэдээж бие бүрэлдэхүүн гараа тогтмол ариутган, амны хаалт зүүж хэвшсэн бөгөөд тэдэнд вирусээс урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж, мэдээллийг байнга өгч байна. Мөн командлалын нэгтгэл,

ангиудад коронавирусуудыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, заавар, зөвлөмж болоод бусад мэдээллийг албан тоотой хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байгаа. Үүний сацуу командлалын байранд гаднаас нэвтрэгчдэд эрүүл ахуйн тодорхой шаардлагуудыг тавьж байна" гэлээ.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

## ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОН ХҮРТЭВ

Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч В.Энхболд НҮБ-ын төв штабт алба хааж буй хурандаа Д.Мягмаржавыг хүлээн авч уулзан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цэргийн гавьяаны одон хүртсэнийг нь гардуулав. Хурандаа Д.Мягмаржав нь НҮБ-ын Энхийн ажиллагааны газарт энхийн ажиллагаа хариуцсан офицероор 2019 оны 12 дугаар сараас эхлэн алба хааж байна. Тэрээр Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад явагдаж буй НҮБ-ын "MINUS-CA" энхийг сахиулах ажиллагааны асуудлыг хариуцдаг бөгөөд НҮБ-аас зарласан сонгон шалгаруулалтад тэнцэн алба хааж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний хоёр дахь офицер юм.

НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газрын цэргийн зөвлөх, бригадын генерал Б.ДАВААДОРЖ



## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ 400 ШИРХЭГ МАСК ХАНДИВЛАЛАА



Коронавирусийн халдварын эсрэг тэмцэх хандивын аянд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний анги, байгууллагууд болон энхийг сахиулагчид нэгдсээр байгаа билээ. Энэ удаад Батлан хамгаалах яамны харьяа "Алдар" спорт хорооны үндэсний сурын

баг, тамирчдаас "COVID 19"-ийн халдвараас урьдчилан сэргийлэх онцгой дэглэмийн үед чухал шаардлагатай байгаа нэг удаагийн 400 ширхэг амны хаалтыг Цэргийн төв эмнэлэгт хандивлалаа. Хандивыг үндэсний сурын багийн дасгалжуулагч,

Монгол Улсын даян мэргэн, хошууч Д.Норжмаа, багийн ахлагч, Монгол Улсын мэргэн, ахлах дэслэгч Б.Баярсайхан, Монгол Улсын тод харваач, ахлах ахлагч Д.Мөнхгэрэл нар Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа С.Батболдод хүлээлгэн өгөв. Энэ үеэр хошууч Д.Норжмаа "Өвчлөл ихтэй улс орнуудаас ирж байгаа иргэдийнхээ эрүүл мэндэд анхаарч, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа Цэргийн төв эмнэлгийн эмч, ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор баг тамирчдаас төлөөлөн энэхүү хандивыг өргөн барьж байна" гэсэн юм.

Мөн хурандаа С.Батболд "Энэхүү сэтгэлийн дэм дулаар хэмжигдэхгүй их үнэ цэнтэй. Бидний ажлыг дэмжиж, сэтгэл зурхээрээ хамт байгаа та бүхэнд талархал илэрхийлье" гэв.

## ЗАСАГ ДАРГА АМЖИЛТ ХҮСЭВ



Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа Г.Эрдэнэбаатарыг Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Н.Энхбат нар хүлээн авч уулзан, ажилд нь амжилт хүслээ. Энэ үеэр Засаг дарга Ч.Раднаабазар хэлэхдээ "Дүүргийнхээ төрийн захиргааны байгууллагуудтай ямагт уялдаа холбоотой ажиллаж, хөгжил цэцэглэлт,

бүтээн байгуулалтын ажилд хамтран оролцож, дэмжлэг тусалцаа үзүүлсээр ирсэнд талархдаг юм. Бидний цаашдын хамтын ажиллагаа улам бүр бэхэжнэ гэдэгт итгэлтэй байна. Коронавирусийн халдварын эрсдэлтэй энэ цаг үед алба хаагчдынхаа аюулгүй байдалд онцгойлон анхаарч халдварын эрсдэлээс хамтдаа сэргийлэхийг уриалж байна" гэв.

## АХМАД УРАН БҮТЭЭЛЧИД ХАНДИВЫН АЯНД НЭГДЛЭЭ



"Зэвсэгт хүчний соёл, урлагийн ажилтны холбоо"-ны дэргэдэх "Цэргийн алдар" дуу бүжгийн чуулгын ахмад уран

бүтээлчид Цэргийн төв эмнэлэгт амны хаалт хандивлалаа.

Ахмад уран бүтээлчдийг төлөөлж тус чуулгын дарга, МУСТА Д.Мөнхзаяа, МУСТА Н.Сумьяа, СТА Г.Наранцэцэг нарын хүмүүс "Дэлхий нийтэд хурдацтай тархаж буй "COVID-19" өвчний эсрэг тэмцэх аянд манай чуулгын ахмад уран бүтээлчид нэгдэж байна. Сүүлийн үед амны хаалтны эрэлт хэрэгцээ ихсэж, мөн хомсдол үүссэн. Тиймээс хүн ардынхаа эрүүл мэндийн манаанд зогсож, тэргүүн шугаманд үүрэг гүйцэтгэж буй та нартаа бага ч атугай дэм өгөхийг хүссэн юм" гээд Цэргийн төв эмнэлгийн Мэдрэлийн клиникийн дарга, ахлах дэслэгч Н.Золжаргалд 400 ширхэг амны хаалтыг хүлээлгэн өглөө.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ ХИЛИЙН ЧАНАДААС МЭДЭЭЛЖ БАЙНА

## "МАРШ"-ИЙН МАНЛАЙЛАГЧИД ТОДОРЛОО



(Түрүүч нь I нүүрт)

Тус тэмцээн гарааны өмнө болон маршийн замд гүйцэтгэх ажиллагаа гэсэн хоёр үе шаттайгаар явагдсан бөгөөд тэмцээнд 12 тасаг оролцон хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм. Маршийн нэгдүгээр шатны даалгавруудыг гүйцэтгэсэн хувийн амжилтаар буюу галын бэлтгэлийн 12 дугаар нормативаар ахлагч Ч.Мөнх-Эрдэнэ, 13 дугаар нормативаар дэд ахлагч Г.Цэнд-Аюуш, 15 дугаар нормативаар дэд ахлагч Б.Ананд, цэргийн биеийн тамирын норматив буюу 10 дугаар дасгалаар дэд ахлагч М.Энхбат, 13 дугаар дасгалаар ахлагч Д.Отгонбаяр, 22 дугаар дасгалаар ахлагч Б.Өсөхбаяр нар тус тус эхний байруудад шалгарлаа.

Тасгууд нэгдүгээр шат буюу гарааны өмнө гүйцэтгэх бэлтгэл дээр жагсаалын

болон гардан тулааны үзүүлэх тоглолт, галын бэлтгэл, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах мөн цэргийн биеийн тамирын бэлтгэлийн нормативуудыг, хоёрдугаар шат буюу 3000 метрийн гүйлтийн замд (хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, зэвсэг, сум галт хэрэглэлтэйгээр) тасгийн бие бүрэлдэхүүн хүн эмнэлгийн норматив, техникийн татан гаргалтыг хийж гүйцэтгэсэн юм.

Өгөгдсөн эдгээр даалгаврыг амжилттай биелүүлэн эр зориг, тэсвэр хатуужил, ур чадвар, цэрэгжилтийн бэлтгэлжилт, жагсаалч байдлаараа бусдыгаа манлайлж нийлбэр дүнгээр ахлах ахлагч М.Цэрэнням захирагчтай тасаг тэргүүн байрт, ахлах ахлагч Б.Төвжаргал захирагчтай тасаг дэд байрт, ахлах ахлагч С.Очирбат захирагчтай тасаг гутгаар байрт тус тус шалгарлаа.

## "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UN-MISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 99 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ хүрээнд офицеруудын дунд дартс шидэлтийн аварга шалгаруулах тэмцээн, батальоны нэгдсэн тооллого, ёслолын буудлага, үлээвэр хөгжимчдийн үзүүлэх тоглолт, жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг зохион байгуулж, цэрэг-эх оронч дуу, бүжиг, уран бүтээлүүдээс бүрдсэн 30 үзүүлбэр бүхий хүндэтгэлийн тоглолтыг бие бүрэлдэхүүнд сонирхуулав.

Баярын концертод зориулан "Цэрэг бүжгийн чуулбар", "Цэгцэрсэн жагсаалын жавхаа", "Тогооч цэргийн наргиант бүжиг", "Тусгай салаа" зэрэг дөрвөн шинэ бүжгийг дэглэж тавилаа.

Тоглолтод нийт 50 гаруй цэргийн алба хаагч дуу хуур, шүлэг найраг, бүжгийн үзүүлбэрүүдээр хамт олноо хөгжөөж оролцсон юм. Концертын төгсгөлд ЦДБЭЧ-аас бэлтгэж ажиллагааны газар оронд ирүүлсэн "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр" тэмцээний торгон өргөмжлөлийг уг тэмцээнд амжилттай оролцсон ангиудын төлөөлөлд гардуулж, үлээвэр хөгжимтэй үдэшлэгийг зохион байгуулсан юм.

Мөн хоногийн манаа, ээлжтэй байсан бүрэлдэхүүнд болон Их Британи улсын цэргийн багийн инженерийн ротын 50 орчим цэргийн алба хаагчдад баярын концертыг бүрэн хэмжээгээр толилуулав. Монгол Улс, Зэвсэгт хүчнээ сурталчилсны зэрэгцээ Наурыз буюу "Нарны баярын өдөр"-ийг тохиолдуулан зарим цэргийн алба хаагчдад хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйлс гардуулав.

Ахмад Д.МЭНДБАЯР

ҮБХИС

## НЭГ САЯ ТӨГРӨГ, 1000 АМНЫ ХААЛТ ...

"COVID-19" өвчний халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ҮБХИС-ийн Ахлагчийн сургуулийг 2008 онд төгссөн ахлагч нарын санаачилгаар "Хамтдаа тэмцэе" уриатай сайн үйлсийн аяныг өрнүүлж 67 цэргийн алба хаагч 1 сая төгрөгийн хандив цуглуулан 1000 ширхэг амны хаалтын хамт нийгмийн зорилтот бүлгийнхэн болон зарим албан байгууллагын ажилтан албан хаагчдад хүлээлгэн өгсөн байна.

Дэд хурандаа О.ИЧИННОРОВ

Редакцын шууданд

325 дугаар анги

Завхан аймгийн алслагдсан сумдад цас ихээр орсны улмаас өвөлжилт хүндэрсэн тул малчдад туслах ажлын хүрээнд ЗХЖШ-ын даргын тушаалаар тус ангиас 11 цэргийн алба хаагч, таван нэгж техник Их-Уул, Баянтэс, Нөмрөг, Баянхайрхан сумдад ажиллаж байна.

Ахмад Н.МӨНХБААТАР

013 дугаар анги

Ангийн алба, салбарууд 2020 оны 3 дугаар сарын үйл

ажиллагаагаа дүгнэлээ. Дүнгийн хуралд штабаас томилогдсон албан тушаалтнууд оролцож, хамт олны саналыг сонсон үүрэг чиглэл өгч, бие бүрэлдэхүүнд "COVID-19" өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар эмнэлгийн албанаас бэлтгэсэн зөвлөмжийг хүргэв. Мөн "Эрүүл орчин" аяны хүрээнд албаны өрөө, тасалгаа, цэргийн байрууд, цэргийн гал тогоонд чийгтэй цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.

Хошууч Ж.ТӨГСМАНДАХ

# 9500 ОРЧИМ ТОНН ШАХМАЛ ТҮЛШ БЭЛТГЭЖЭЭ

Өнгөрсөн жил Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон Засгийн газрын 62 дугаар тогтоол гарч, нийслэлийн иргэд шахмал түлшийг хэрэглэх болсон. Жил бүрийн өвөл нийслэлийн иргэдээс “угаартаж үхлээ” гэсэн шүүмжлэл гардаг. Битүү саарал утаа хотыг нэлэнхийд нь бүрхэж, хоолой, ам хорсоно. Хэдхэн алхмын зайд хэн нэгнийг харах гэж зүдэрнэ. Хүүхдүүд эмнэлгийн коридорт “шалаар нэг” хэвтэж, ээлж дараалан уйлалдана. Ийм л дүр төрхөөр бид өвлийг төсөөлдөг болоод уджээ. Энэ жил харин утаа нүдэнд харагдахуйц буурч, тэнгэр цэлмэг, агаар тунгалаг байдаг болсон. Хоолой хорсож, хувцсанд утаа шингэхгүй. Ёстой л “Агаарын бохирдлыг бууруулахад ийм амархан байсан гэж үү” хэмээн дуу алдмаар сайхан.

Гэхдээ энэхүү үр дүнг ганц бид мэдрээд байгаа юм биш ээ. Швейцар улсын “Дэлхийн агаарын индекс” байгууллагаас гаргасан судалгаанд манай улс 2018 онд дэлхийн 100 улсын сүүлийг мушгиж байсан бол энэ жилээс 32 дугаар байрт ортлоо урагшилжээ. Улаанбаатар хотын урд 31 дүгээр байрт Чехийн нийслэл Прага хот орсон бол манай улсын ард 33 дугаар байрт Словакийн нийслэл Братислав хот орсон байх жишээтэй. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын агаарын чанарын индекс 96 хувь буюу Японы Осака, Нагоя хотууд шиг цэвэрхэн байна гэсэн үг.

Энд онцлоход, Монгол Улсын Засгийн газрын энэхүү шийдвэрийг амжилттай хэрэгжүүлэхэд хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын оруулсан хувь нэмэр их гэдгийг хэлэх гэсэн юм. Төр, засгаас явуулж байгаа агаарын бохирдлыг бууруулах бодлогыг дэмжиж, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран ажиллалаа. Тус ажлын хүрээнд ЗХЖШ-ын даргын 2019 оны тушаал, “Таван толгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн гэрээний дагуу Зэвсэгт хүчний 013, 016, 119, 120, 326 дугаар ангиас найман офицер, 150 хугацаат цэргийн алба хаагч 2019 оны 11 дүгээр сарын 25-наас 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд үүрэг гүйцэтгэлээ.

Бие бүрэлдэхүүн “Таван толгой түлш” ХХК-ийн Тахилт, 22-ын товчоо, Яармаг дахь гурван байрлалд 09.00 цагаас 18.30 цаг хүртэл ажлын найман цагаар долоо хоногийн зургаан өдөр үүргээ амжилттай гүйцэтгэсэн байна. Хугацаат цэргийн алба хаагчдыг хариуцан ажилласан Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн холбооны батальоны захирагч, хошууч Ө.Баярбадрах хэлэхдээ “Манай цэргүүд үүргээ маш сайн гүйцэтгэсэн. Тэдний ажлын үр дүнд “Таван толгой түлш” ХХК-ийн удирдлага, ажилчид сэтгэл хангалуун байгаагаа удаа дараа илэрхийлсэн. Мөн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний ангиудын удирдлага болоод Нийслэлийн Засаг даргын Тамгын газар ч бид бүхний идэвх оролцоог үнэлж, цэргүүдэд урам хайрлаж байсныг дурдахад таатай байна. Улаанбаатар хотын удирдлага, иргэд утаатай 10 гаруй жил тэмцэлдсэн ч энэ жилийнх шиг ийм өндөр үр дүнд хүрсэн удаа байхгүй. Энэ ажилд манай цэргүүдийн оруулсан хувь нэмэр их гэдгийг нэмж хэлэх нь зүйтэй болов уу. Цаашид ч бид нийслэл хотынхоо агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулан үүрэг гүйцэтгэхэд бэлэн” гэсэн юм.

Цэргүүд шахмал түлш боловсруулах үйлдвэрт гар савлагаа, автомат савлагаа, ачилт, буулгалт гэсэн үндсэн ажлыг хийдэг байжээ. Гар савлагаа гэдэг нь үйлдвэрийн задгай талбайд буусан шахмал түлшийг шигшүүрт шигшин шуудайлж, жиллээд амсрыг нь өбж бэлэн болгохыг хэлдэг аж. Автомат савлагааны дамжлагаар ирж байгаа бэлэн

болсон шахмал түлшийг тосож, тээвэрлэхэд бэлэн болгож өрнө. Ачилт, буулгалтын хэсэгт байгаа цэргүүд бэлэн болсон бүтээгдэхүүнүүдийг авто машинд ачна. Зэвсэгт хүчний ангиудаас туулах чадвар сайтай “ЗИЛ-131” маркийн 28 нэгж авто машинаар зургаан дүүргийн авто машин зорчих боломжгүй өндөрлөг цэгт байрлах айл өрхүүдэд түгээлт хийж байгаа. Тэгвэл цэргүүд тэдгээр шахмал түлшийг ийнхүү бэлтгэж, тээвэрлэлтэд бэлэн болгодог байжээ.

Ингээд шахмал түлш боловсруулах үйлдвэрт ажилласан хугацаат цэргийн алба хаагчид болон иргэдийн сэтгэгдлээс хүргэе.

**ӨӨРИЙГӨӨ АЗТАЙ ГЭЖ БОДОЖ БАЙНА**  
Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн түрүүч **Н.ӨНӨБОЛД**:  
-Би Орхон аймгийн Баян-Өндөр суманд төрсөн ба



2019 оны нэгдүгээр ээлжээр цэргийн албанд татагдан ирсэн. Тэр дундаа баялаг түүхтэй холбооны хороонд алба хааж байгаадаа туйлаас баяртай байна. Улаанбаатар хотын иргэдийг утаагүй өвөлжихөд гар бие оролцох боломжийг олгосон ангийнхаа удирдлага, бие бүрэлдэхүүнд баярлалаа. Ийм боломж цэрэг бүхэнд олддоод байхгүй учраас би өөрийгөө азтай гэж бодож байна. Шахмал түлшийг шигших, шуудайлах, оёх, ачих ажлыг бид үйлдвэрийн стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Үйлдвэрийн ажилтнууд бидэнтэй үргэлж найрсаг харилцаж, санаа тавьж байсан болохоор бид ч ажлаа хийхдээ сэтгэл хангалуун байсныг хэлэхэд таатай байна. Мөн шинэ жилийн үеэр бидэнд баяр хүргэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга Ж.Батбаясгалан, Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар болон бусад ангийн захирагч, штабын дарга нар ирж, баяр хүргэн урмын үг хайрласан нь маш сайхан үйл ажиллагаа болсон. Эх орны хүү, эр цэрэг болно гэдэг ямар сайхан болохыг үгээр илэрхийлэхийн аргагүй юм.

**ЦАЛИНГААРАА ШИНЭ ГЭР ХУДАЛДАЖ АВНА**  
Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн байлдагч **Э.ДЭМБЭРЭЛСАЙХАН**:



-Баянхонгор аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан. Манай гэр бүлийнхэн малчин хүмүүс бөгөөд миний аав гурван жил цэргийн алба хаасан хүн бий. Тийм болохоор ааваасаа цэргийн албаны талаарх дурсамжийг олонтоо сонссон. Мөн “Тусгай салаа” олон ангит уран сайхны киног үзээд цэргийн алба хаах нь зүйтэй юм байна гэж бодох болсон. Зорилгоо ч биелүүллээ. Үнэхээр миний бодсоноор цэрэгт ирээд би олон найз нөхөдтэй болж, өөртөө шинэ

боломжуудыг нээсэн. Тэр дундаа нийслэл хотынхоо агаарын бохирдлыг бууруулах үйлсэд хувь нэмрээ орууллаа. Ажил нь тийм ч хүнд байсангүй. Гэхдээ Улаанбаатар хотын иргэдийг утаагүй түлшээр хангахаар хүмүүс ямар их хүч хөдөлмөр шингээн байж ажиллагдийг би тэнд байхдаа ойлгосон. Цэргүүд бид ажилласан дөрвөн сар гаруй хугацаандаа нийт 9500 орчим тонн шахмал түлшийг шуудайлж бэлтгэсэн. Энэ хугацаанд ажилласан цалингаа халагдахдаа авна. Цалингаараа шинэ гэр худалдаж аваад орон нутагтаа очиж малаа маллах бодолтой байгаа.

**НАДАД ИЙМ БОЛОМЖ ОЛГОСОН ЗЭВСЭГТ ХҮЧИНДЭЭ БАЯРЛАЛАА**  
Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн түрүүч **Г.БОЛД-ЭРДЭНЭ**:



-Би Баянхонгор аймгийн Бууцагаан суманд төрсөн. Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 16 дугаар сургуулийг төгсөөд 2019 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан. ЗХЖШ-ын даргын тушаалаар “Таван толгой түлш” ХХК-ийн шахмал түлш боловсруулах үйлсэд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсандаа баяртай байна. Өмнө нь ийм ажил өрөөсөө хийж үзээгүй миний хувьд үнэхээр сонирхолтой байлаа. Бид өглөө бүр ажилд гарахын өмнө хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавартай танилцаж, гарын үсэг зурдаг байсан. “Таван толгой түлш” ХХК-аас дулаан хүрэм, өмд, гутал, малгай, бээлий, каск, амны хаалт гээд хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангадаг байсныг энд дурдах нь зүйтэй болов уу. Мөн нийт ажилчдад өдөрт хоёр удаа хор саармагжуулах бүтээгдэхүүн болох аарц, аньс, чацарганын шүүс өгдөг. Нэг цэрэг өдөрт дунджаар 130 шуудай сайжруулсан шахмал түлшийг савладаг байсан. Хотыг цэвэр агаартай болгох ийм сайхан үйлсэд иргэн хүнийхээ хувьд, цэргийн алба хаагчийнхаа хувьд хувь нэмрээ оруулсандаа баяртай байна. Түүнчлэн их сургуульд суралцах төлбөрөө хугацаат цэргийн алба хаах хугацаандаа олж авлаа. Надад ийм боломж олгосон Зэвсэгт хүчиндээ баярлалаа.

**ХҮҮ МААНЬ ЭХ ОРНЫ ХҮҮ БОЛЖЭЭ**  
Түрүүч **Э.Цогтбаатарын аав Б.ЭНХБАЯР**:



-Миний хүү Баянгол дүүргээс 2019 оны нэгдүгээр ээлжээр Зэвсэгт хүчний 013 дугаар ангид хугацаат цэргийн албанд татагдсан. Нэгэн орой хүүтэйгээ цэргийн албаны талаар ярилцаад “Миний хүү цэрэгт яваад ирвэл яасан юм бэ. Эр хүн болж төрсний нэгэн хэрэг чинь эх орондоо тангараг өргөх юм шүү” гэж хэлсэн. Тэгсэн маргааш нь миний хүү цэргийн зарлан дуудах хуудсаа барьчихсан “Ааваа,



Гар савлагааны дамжлагад ажиллаж байгаа цэргүүд



Автомат гар савлагааны дамжлагад ажиллаж байгаа нь



Нийслэлийн өндөрлөг цэгүүдэд түгээлт хийх авто машинуудад шахмал түлш ачиж байгаа нь

таны хэлснээр хүү нь цэрэгт явна аа” гэсэн юм. Тэгэхээр нь би ээжид нь хэлчихвэл хүүгээ явуулахгүй гээд уурлаж магадгүй гэж бодоод цэрэгт татагдсан хойно нь эхнэртээ хэлсэн. Ээж нь ч их гайхсан, “Хүүг минь надад хэлэхгүй явууллаа” гээд. Арга ч үгүй биз, хүүдээ санаа зовсон нь илт байсан. Харин одоо Цогтбаатарыг ямар сайхан жавхаалаг эр болсныг хараад ээж нь ч бүс гэр бүлийнхэн нь бүгдээрээ хүүгээрээ бахархаж байгаа. Цэргийн алба хаагаад зогсохгүй Улаанбаатар хотынхоо агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулж, цалинтай халагдана гэдэг бол цэргийн алба хааж байгаа залуусын хувьд ховор боломж юм. Хүү маань анх шахмал түлш боловсруулах үйлдвэрт ажиллахаар томилогдсон гэж хэлэхээр нь санаа зовж л байлаа. Гэхдээ хувцас, хэрэглэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувьд 100 хувь хангагдсан гэдгийг нь сонсоод санаа амарсан. Хүү маань эх орны хүү болжээ.

**ХОТЫН ИРГЭД НҮҮРСНИЙ ҮНЭРЭЭ МАРТСАН**  
Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хорооны иргэн **Т.ЭНХТАЙВАН**:



-Шахмал түлшний илч болоод үнэхээр утаагүй шатдаг эсэхэд нь миний хувьд эхлээд эргэлзэж байсан. 11 дүгээр сараас хойш хэрэглэж байна.

Үр дүн нь ч бидний нүдэнд тод харагдлаа. Хот үнэхээр утаагүй өвөлжсөн. Засгийн газрын хэрэгжүүлсэн шийдвэртэй алхмыг иргэд бид дэмжиж ажилласандаа баяртай байна. Шахмал түлшийг тойрсон сайн, муу асуудлууд энэ өвөлжингөө л хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдлаа. Мэдээж алдаа дутагдалгүй, төгс зүйл гэж юу байх вэ. Цаашдаа жилээс жилд түлшний чанар улам сайжраад явна биз дээ. Би өөрөө тээврийн жолооч учраас хөдөө, орон нутагт очиж ажиллах нь элбэг. Өмнө нь хөдөөгийн иргэд Улаанбаатар хотод ирэхдээ “Бохир агаартай байна, хоолой гашуун оргиод байна” гэдэг байсан бол одоо хотын бид томоохон аймгийн төвд очихоороо тэр үгийг хэлмээр санагддаг болсон байна шүү. Хүн гэдэг амьтан аливаа зүйлд хурдан дасдаг. Аймгийн төв орохоор нүүрсний үнэр содон санагддаг болсон. Тэгэхээр хотын хүмүүс ямартаа ч нүүрсний үнэрээ мартсан гэсэн үг. Ажил маань үүрийн 06.00 цагаас эхэлдэг. Өмнө нь үүрийн харанхуйд утаан дунд эргэн тойрны орчин хязгаарлагдмал нөхцөлд замын хөдөлгөөнд оролцож, ажил руугаа явах үнэхээр хүндрэлтэй байсан. Гэтэл энэ өвөл надад тийм асуудал тулгарсангүй. Энэ бол Улаанбаатар хотын жирийн иргэн хүний хувьд мэдрэгдэж байгаа үр дүн юм. Мөн шахмал түлш түгээх ажилд цэргүүд оролцсоныг сонсоод үнэхээр сайн ажил болж гэж бодсон. Үүгээр ч зогсохгүй эх орны бүтээн байгуулалтад цэргүүд оролцож, улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа нь маш зөв. Би 1999 онд Хилийн цэрэгт алба хаасан. Намайг алба хааж байх үед ийм боломж гарсан бол мөн сайхан сан. Тэр үетэй харьцуулахад өнөөдөр цэргийн алба олон талаар хөгжиж байна.

**Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ**

# НЭГЭН ЗУУНЫ УРЛАЛ БУЮУ "БӨРТЭ"-ГИЙНХӨН

Улсын сүр нь цэрэгтээ гэдэг. Тэрхүү сүр хүчний илэрхийлэл болсон цэрэг эрсийн жавхаалаг байдал, өнгө төрхийг цэргийн дүрэмт хувцасгүйгээр төсөөлөхийн аргагүй. Та бидний өдөр тутамдаа өмсдөг Төрийн соёмбоо орой дээрээ залсан малгайнаас эхлээд китель, өмд, хүрэм зэрэг олон нэр төрлийн цэргийн дүрэмт хувцсыг урлах, цаг үеэ мэдэрч, загварыг нь шинэчлэх эрхэм үүргийг хүлээсэн зуун жилийн түүх, зузаан намтартай нэгэн үйлдвэрийг энэ удаад онцолж байна. Мэдээж уншигч таны мэлмийд "Найман шарга төв"-ийн өөдөөс харсан хуучны хоёр давхар шар байшингийн дүр зураг буусан байх. Анх 1921 онд Жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар Ардын журамт цэргийн хувцас, хэрэглэлийг сэлбэн засах оёдлын бүлгэм бий болж, улмаар 1922 оны эхээр "Бэлтгэн үйлдэх тасаг" нэртэйгээр цэргийн гар үйлдвэр албан ёсоор байгуулагдсанаар одоогийн "Бөртэ" ТӨААТҮГ-ын түүх бичигдэж эхэлжээ.

Тус үйлдвэрийн хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хэрэгцээт дүрэмт хувцсыг чанар, стандартын өндөр



Хурандаа Б.ЭРХЭМБАЯР

загварыг оюуны өмчөөр баталгаажуулах ажлыг шуурхай зохион байгууллаа. Мөн Батлан хамгаалах яамны санхүүжилтээр орчин үеийн стандартад нийцсэн цахим үлгэрийн системийг үйлдвэртээ нэвтрүүлээд амжлаа. Өмнө нь заавал гар ажиллагаа шаарддаг байсан бол цахим үлгэртэй болсноор ажилчдын хөдөлмөрийн бүтээмж дээшилж, цаг хугацааг ч хэд дахин хэмнэсэн зэрэг олон давуу тал бий болсон. Манай үйлдвэр БХЯ-ны санхүүжилтээр орчин

Дараагийн дугаарт, 2020 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүргийн дагуу Төрийн хүндэт харуул, морьт торгон цэргийн болоод цэргийн ёслолын хувцас, хэрэглэлийг шинэчлэх ажилд тус үйлдвэрийнхэн гол ажлыг нугалж байгааг онцлох нь зүйтэй.

Мэргэжлийн бус хүний нүдээр харахад ч энэ ажил өндөр үүрэг хариуцлага, зохион байгуулалт, нарийн мэдрэмж шаарддаг гэж болохоор байв. Тухайлбал, хувцас загварлаг, орчин үетэйгээ нийцсэн, чанартай зэрэг сонголтыг аль болох өргөн байлгах үүднээс уралдаан зарласан байна.

Эл уралдаанд ирүүлсэн

**Өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан 4000 ширхэг амны хаалтыг оёж үйлдвэрлэн ЗХЖШ, УБХИС, Цэргийн төв ЭМНЭЛЭГТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН нь тус хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд ч идэвх, санаачилгатай ажилладгийн тод илрэл юм.**

загвар бүр дээр ач холбогдол өгч тухайн уран бүтээлчидтэй нь хамтарч цаасан дээр буусан зураглалыг бодитоор оёж, үйлдвэрлэн бэлэн бүтээгдэхүүн болгон өөр хооронд нь харьцуулан дүн шинжилгээ хийх гэх мэтээр гурван сар гаруйн турш ачаалал үүрч ажиллажээ.

Мөн өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан 4000 ширхэг амны хаалтыг оёж үйлдвэрлэн ЗХЖШ, УБХИС, Цэргийн төв эмнэлэгт хүлээлгэн өгсөн нь тус хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд ч идэвх, санаачилгатай ажилладгийн тод илрэл юм.

"Бөртэ" ТӨААТҮГ нь эсгүүрийн, гүйцэтгэх, захиа, китель болон өмдний гэсэн таван тасагтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Тасаг бүр өөр өөрийн онцлог, гүйцэтгэх үүрэгтэй. Жишээлбэл, эсгүүрийн тасаг нь зургийн дагуу нарийвчилсан огтолгоо хийнэ. Үүний дараа нэг бүрчлэн дугаарлаж бусад тасаг

Өөрөөр хэлбэл хувцас арчлах соёлыг дээд зэргээр сахидаг аж.

Хамгийн онцлогтой нь захиа тасаг. Тус тасагт тухайн хүн биеийнхээ хэмжээг өгч, түүнийх нь дагуу ажилтнууд хувцсыг нь оёж үйлдвэрлэдэг. Мөн генералуудын мөрдэсийг оёно. Бусад тасагт нэг нь халаас, нөгөөх нь зах залгах гэх мэт шат дамжлагатай бол энд тэр бүгдийг ганцаарчлан гүйцэтгэдгээрээ ихээхэн ялгаатай. Түүнчлэн оёдлын гурван тасгаас ирсэн бүтээгдэхүүнүүд захиа тасгаар дамжихаас гадна чанарыг нь мөн энд шалгаж баталгаажуулдаг аж.

Аливаа албан байгууллагын ажиллах хүчний цөмийг залуус бүрдүүлдэг. Мөн тэд ахмадуудаасаа үлгэр дуурайл авч, юу сурч мэдсэнээ дараа дараагийн үеийнхэндээ өвлүүлж, эзэмшүүлснээр тухайн байгууллага ч урт удаан



Мастер М.ТУНГАЛАГ

руу хуваарилах, наалт хийх гэх мэт олон ажилбарыг хийж гүйцэтгэнэ. Хамгийн сүүлд эсгүүрийн тасгаас гарсан материалууд оёдлын тасгуудад хүргэгдэж бэлэн бүтээгдэхүүн болох замдаа ордог аж. Ерөнхийдөө эсгүүрээс эхлээд бүх бэлтгэл ажлыг хангадаг гэж хэлж болохоор. Өнгөрсөн онд эсгүүрийн тасаг шинээр батлагдсан цэргийн дүрэмт хувцаснуудыг бэлтгэн нийлүүлэхэд богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажилласнаас гадна төлөвлөгөөгөө давуулан биелүүлж "Тэргүүний тасаг"-аар шалгарчээ.

Энэхүү амжилтын эздийн нэг тасгийн мастер М.Тунгалаг тус үйлдвэрт 37 дахь жилдээ тасралтгүй ажиллаж байна. Тэрээр анхлан тус үйлдвэрт оёдолчноор ажиллаж эхэлсэн бөгөөд эрхэлсэн ажилдаа эзэн нь болж, ногдсон үүргээ сайн биелүүлсээр өдгөө мастерын зэрэгт хүрчээ. Түүний хувьд төлөвлөсөн ажлаа цаг хугацаанд нь хийж гүйцэтгээд амсхийх үе хамгийн сайхан нь. Мөн зөвхөн өөрийн ажлыг боллоо гээд санаа амралгүй бусдадаа, ялангуяа залууст хамгийн ихээр анхаарал тавьдаг нь тасагтаа үлгэр дуурайл болдог гэж сайшаах хүн олон таарсан юм.

хугацаанд оршин тогтнодог онцлогтой. "Бөртэ" ТӨААТҮГ-ын хувьд нийт ажилтан албан хаагчдын 50 гаруй хувь нь залуусаас бүрддэг. Энэ талаар хурандаа Б.Эрхэмбаяр "Манай үйлдвэр МСҮТ-д бэлтгэгдсэн залуусаас ажилтнуудаа шалгаруулж авдаг. Төр, засгаас МСҮТ-д суралцаж байгаа оюутнуудыг дэмжих үүднээс сар бүр тэтгэлэг олгодог болсон нь чанартай боловсон хүчин бэлтгэгдэхэд томоохон хөшүүрэг болсон гэж боддог. Даалгасан ажлын гүйцэтгэл болон хандлагын хувьд ч залуус маань манлайлдаг. Бид залуустаа итгэдэг" гэв.

Энд нэг зүйлийг хэлэхэд үйлдвэрийн ажилтан албан хаагчдын хувьд үүргийн биелэлтээ бүрэн хангаж ирсэн ч ая тухтай орчинд ажиллах, нөхцөл бололцоогоор дутмаг байгаа нь мэдрэгдсэн. 1962 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулсан учраас тус барилгын өнгө үзэмж муудан, зарим хэсэгт нь ан цав үүсэж, даац муудсан зэрэг насжилт нь гүйцсэн гэдгийг нотлох зүйлс олон. МХЕГ-аас ч үйл ажиллагааг хязгаарлах анхааруулга, санамж бичгүүд ирсэн нь тус үйлдвэрийн барилгаа хэдийнээ чанарын шаардлага



Огтолгоо хийгдэж байна

түвшинд үйлдвэрлэн бэлтгэж нийлүүлдгээрээ бусад үйлдвэрээс онцлогтой. "Бөртэ" ТӨААТҮГ өнгөрсөн онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн хангахын зэрэгцээ ажилтан, алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд зарим ажлыг хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал, Батлан хамгаалах яам, ЗХЖШ, тэдгээрийн харьяа анги, байгууллагуудын болоод Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын 4,8 тэрбум төгрөгийн өртөг бүхий цэргийн дүрэмт хувцсыг оёж захиалагчдад нийлүүлжээ. Ингэхдээ 240 гаруй сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэдгийг ерөнхий захирал, хурандаа Б.Эрхэмбаяр онцолсон. Мөн тэрээр "2018 оны

үеийн стандартад нийцсэн тоног төхөөрөмжүүдээр хүчээ сэлбэсэн учраас өндөр бүтээмжтэй ажилладаг" гэв.

Үйлдвэрийн харьяанд нийт 300 гаруй ахмад байдаг аж. Үйлдвэрийн ажилтан албан хаагчид болон тэдгээр ахмадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт газар авч зургаан гэртэй амралтын газрынхаа суурийг тавьжээ. Тэд өөрсдийн нөөц бололцоогоор бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж, эхний ээлжинд ахмадууд болон ажилтан албан хаагчдадаа үнэ төлбөргүйгээр үйлчилж эхэлсэн байна. Энэ нь хамт олноо нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд хийгдэж байгаа ажил, нөгөөтэйгүүр тэдний сэтгэл

загвар бүр дээр ач холбогдол өгч тухайн уран бүтээлчидтэй нь хамтарч цаасан дээр буусан зураглалыг бодитоор оёж, үйлдвэрлэн бэлэн бүтээгдэхүүн болгон өөр хооронд нь харьцуулан дүн шинжилгээ хийх гэх мэтээр гурван сар гаруйн турш ачаалал үүрч ажиллажээ.



Эсгүүрийн тасагт



Гүйцэтгэх тасагт

12 дугаар сард цэргийн дүрэмт хувцасны шинэчилсэн загварыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлуулсан. Ингээд 2019 онд загварын дагуу үлгэрийг нь гаргах, үйлдвэрлэлд шилжүүлж, оёдлын технологийг нэвтрүүлэх чиглэлээр нэлээд шахуу ажилласан. Үүнтэй уялдуулан шинээр батлуулсан цэргийн дүрэмт хувцасныхаа

ханамжийг дээшлүүлэх нь чухал учраас тус амралтын газрыг улам хөгжүүлж, орчин нөхцөлийг нь сайжруулах үүднээс төвийн эрчим хүчээр хангах асуудалд анхаарч байгаа аж. Үүнд БХЯ-ны зүгээс дэмжлэг үзүүлж 60 гаруй сая төгрөгийн санхүүжилтийг шийдэж өгсөнд үйлдвэрийн ажилчид талархаж, сэтгэгдэл өндөр байгаагаа илэрхийлсэн.

Үр дүнд нь 10 гаруй загварыг боловсруулан хүндэт харуулын шинэ загварын хувцасны төслөө Батлан хамгаалах яамны сайдын зөвлөлд танилцуулаад байгаа аж.

Дээрх ажлуудаас гадна цар тахлын хурцадмал байдлын үед Улсын онцгой комиссын даалгавраар 45 мянган амны хаалтыг оёж ОБЕГ-т өгсөн байна.

Бусад тасгаас ирсэн тухайн хувцсыг бэлэн бүтээгдэхүүн болгоход гүйцэтгэх тасгийн үүрэг өндөр. Тухайлбал, хувцсаа нүхлээд, тушаа хэсэгт нь товчоо хадна. Хүн харахад цэргийн дүрэмт хувцас гэж ойлгогдох ч үрчийж, хуниралдсан байвал зохимжгүй. Тийм учраас зориулалтын индүүгээр индүүдэж, савлагаанд оруулна.

хангахаа больсны илрэл юм. Сурвалжиглын төгсгөлд тус үйлдвэрийн удирдлагууд ажилтан албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрх хөндөгдөж байгаа тул чанарын шаардлага хангасан үйлдвэрийн шинэ барилгатай болох хүсэлтэй байдгаа илэрхийлсэн юм.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

Хувьсгалт тэмцэлийн ахмад зүтгэлтэн 1939, 1945 оны дайнд оролцогч, дэд хурандаа Балдангийн ДЭМЧИГ

(Түрүүч нь №10)-т

Нөхөр Б.Дэмчиг зөвхөн дайн болсон дөрвөн сарын хугацаанд ч биш 1939 оны 1 дүгээр сарын сүүлчээс 9 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл маш их идэвх зүтгэлтэй үүрэг гүйцэтгэсэн нь түүнийг хороо, дивиз, цэргийн командлалаас төрийн шагналд тодорхойлж байсан баримтаас харагддаг. Зургаадугаар морьт дивизийн 15 дугаар морьт хорооны Халхын голын байлдаанд амжилт гаргасан хүмүүсийг шагнуулах тодорхойлолтын 14-д "Б.Дэмчиг. Завхан аймаг Жавхлант сум. 7 дугаар баг. 6 дугаар сарын 6-ны өдөр дайсны 2 суман илүү

командлалаас явуулсан үзлэг, шалгалтад удаа дараа "Сайн" үнэлэлт авчээ. 14 дүгээр морьт хороо 1943 оны командлалын шалгалтаар "Сайн" шалгагдаж байсан учир байлдааны хүнд үүрэг даалгаврыг дивизээс 14 дүгээр морьт хороонд, хорооноос 2 дугаар суманд өгдөг байсан нь дайны үед МАХЦ-ийн Улс Төрийн газрын туслахаар ажиллаж байсан Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хурандаа Х.Сэтэвийн дурсамж, архивын баримтаас харагддаг. Ийм учраас 1945 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн өглөөний 04.30 цагт хил давахаас эхлээд дивиз, хорооны маршийн аяны аюулгүй байдлыг ханган, Японы харуулын үлдэгдлийг

"... Чи Өвөр Монголын Шилийн голын чуулганы хошуудын нутгаар явж, Чөлөөлөх дайны ариун зорилго, БНМАУ-ын 25 жилийн хөгжил, Монголын ард түмний эрх чөлөөт амьдралын тухай таниулга хийж, Монголын армид сайн дураараа уналга сэлбэх агт морьд бэлэглэвэл авч, дивизүүдийн замыг тосон нийлүүл" гэсэн үүрэг авч Өвөр Монголын ардуудад ухуулга хийж (10000 гаруй хүнд), нутгийн иргэдээс МАХЦ-т 3000 агт авах ажлыг зохион байгуулан, 5, 6, 8 дугаар морьт дивизүүдийн замыг тосон нийлүүлж онцгой гавьяа

ангиудад Намын хорооны нарийн бичгийн даргын албыг хашиж байгаад гавьяаныхаа амралтад гарчээ.

Барилгын цэргийн 110 дугаар анги 1968-1970 онд Мөрөн хотын Аэрологийн станцын барилга, Хатгал, Ханхын дамжлага баазуудын өргөтгөл-шинэтгэл, усан онгоцны дөрвөн зогсоолын байгууламж, 40 тонн мах хадгалах мөсөн зоорь, Хатгалын нефть баазын өргөтгөл, технологийн өвөрмөц нарийн шийдэлтэй, манай улсын түүхэнд анх удаагаа хийгдсэн усан онгоцны зогсоолын байгууламжийг Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн хамт барьж,

цэрийн ангиуд хийж гүйцэтгэхэд 164 дүгээр анги шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. 1970-1980 оны үед Барилгын цэргийн системийн хэмжээнд үйлчлэх зориулалтай, маневарлах чадвар сайтай, орчин үеийн өндөр хүчин чадалтай тээврийн авто машин, төрөл бүрийн хүнд механизмуудтай 164 дүгээр ангийг байгуулахаас нь эхлээд нийт бие бүрэлдэхүүнийг эв нэгдэлт, сахилга журамтай, хамт олонч, бүтээлч, хөдөлмөрч болгон төлөвшүүлсэн нь намын хорооны дарга Б.Дэмчигийн үйл ажиллагааны үр шим байв. 1977 онд ахлагч, тракторчин У.Батмөнх армиас төрсөн анхны БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар болж,

# ЦАГААН УЛСЫН "ХҮРЭН БҮРТЭЭД"

## ХАЛХЫН ГОЛЫН ТЭНГЭРТ ДҮҮЛСЭН НЬ

этгээдтэй байлдахад тэрхүү дайсны хянагч нэгийг винтгоороо алсан ба сахилга журмыг нэг ч гажуудуулсангүй, дарга нарын тушаалыг онц сайнаар биелүүлдэг. Ялангуяа эвлэлийн гишүүний хувиар байлдагч, дарга цэргүүдийг (энд байлдагч гэдгийг цэргийн цол гэсэн агуулгаар биш байлдагч, тулалдагч гэсэн утгаар хэрэглэжээ) эвлэлийн ба нам, олон түмний ажлаар сурган хүмүүжүүлэх ажилд онц идэвхтэйгээр ажилладаг болох тул нэгдүгээр зэргийн шагналаар шагнуулахыг хүснэ" /сан 1. Данс 4. хн 75. х 43/ гэжээ.

1940 онд "Август" дурсгалын тэмдэг гарч, энэхүү тэмдгээр шагнагдагсдын 662-д "15 дугаар хорооны 2 дугаар сумангийн салааны туслах Б.Дэмчиг" /сан 1. Данс 4. хн 75. х 49/ гэсэн байна. Хамгийн эцэст шагнуулахаар тодорхойлсон жагсаалтын 9-д "Б.Дэмчиг. наводчик. Завхан аймаг. Жавхлант сум. Дөрөвдүгээр сараас эхлэн заставт (Шигшмэл суманд үүрэг гүйцэтгэснийг тодруулсан) харуул манааны үүрэг ба хэсүүл, тагнуулын үүргийг онц сайнаар гүйцэтгэсэн, 5 дугаар сарын 29-ний өдөр Японы цэргээс гурвыг алсан, 6 дугаар сарын 1-ний байлдаанд мөн дайсны гурван япон цэрэг алсан ба 8 дугаар сарын 20-ны байлдаанд хэсүүл, тагнуулын үүргийг онц гүйцэтгэсэн. 6 дугаар сарын 29-ний өдөр тагнуулд явж байгаад тасаг гаруй япон цэргээс нэгийг алж, бусдыг нь ухраасан байна. Энэхүү нөхрийг нэгдүгээр зэргийн цусан гавьяаны одонгоор шагнахыг хүснэ" /сан 1. Данс 4. Хн104./ гэжээ.

Цэргийн Ерөнхий сургуульд суралцуулах тодорхойлолтод "Наводчик Б.Дэмчиг. Завхан аймаг. Жавхлант сум. 7 дугаар баг. Цагаан ба эсэргүү бослогод оролцогүй. Ял шийтгэлгүй. 5 дугаар сард фронтод ирж ажилласнаас хойш 5 дугаар сарын 28-нд Япон, Баргын хоёр цэргийг туйлын баатарлагаар барьж авсан ба сахилга журам сайн тул цэргийн сургуульд явуулах" /сан 1. Данс 4. хн 75. х 43/ гэжээ.

### Говь хянганд тулалдсан нь

Халхын голын дайнаас БНМАУ-ын МАХЦ-ийн цаашдын хөгжил дэвшилд олон сургамж өгсний нэг нь цэргийн даргалах бүрэлдэхүүнийг сургах, бэлтгэхэд анхаарах асуудал байлаа. Юуны өмнө дайнд амжилттай оролцож, туршлага хуримтлуулсан тэргүүний дайчдаас цэргийн сургуульд суралцуулж, цэргийн дарга болгох зорилгоор БНМАУ-ын баатар Ц.Олзвий нарын дайчдыг сонгосны дотор 15 дугаар морьт хорооноос хоёрдугаар сумангийн ХЗЭ-ийн үүрийн дарга, бага дарга Б.Дэмчиг багтаж 1943 онд Цэргийн Ерөнхий сургуулийн улс төрийн ангийг дүүргэсэн юм. Тэрээр 5 дугаар морьт дивизийн 14 дугаар морьт хорооны 2 дугаар суманд улс төрийн орлогчоор томилогджээ. Сумангийн улс төрийн орлогч Б.Дэмчиг дайнд явахад тус суман даргагүй байсан тул сумангийн даргаар оролцжээ. 1945 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн оройноос 5 дугаар морьт дивиз Сүхбаатарын Дарьгангын Наранбулаг хүртэл 400 км-ийн марш үйлдэж командлалаас заасан заагт хүрч байрлан, дайн эхлэх хүртэл бэлтгэл ажил хийх хугацаанд залуу дэслэгч Б.Дэмчиг сэлэмт сумангаа чадварлаг зохион байгуулж, дивизийн удирдлага, МАХЦ-ийн

бут цохих, баривчлах, олзлох үүргийг гүйцэтгэж, 8 дугаар сарын 16-ны өдөр Долоннуурыг эзэлжээ. Улмаар Хянганы уулсыг давж, олон тосгон, суурин, Жэхэ, Губэйкоу хотуудыг чөлөөлөв. Губэйкоу хот бол Монгол Улсын хилээс 1010 км зайд орших Хятадын төмөр замын зангилгаа. Энэ хотод байсан Японы эзэн хааны 8 дугаар корпусын штабын дарга, дэд хурандаа Очигийн командалсан 31, 35 дугаар тусгай отряд, 76 миллиметрийн их бууны 11 дүгээр батарей, 1300 цэрэг, 59 офицерыг удирдлагын хамт олзолжээ.

Цагаан хэрэмийг эзлэхэд дэслэгч Б.Дэмчиг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснийг дайнд 5 дугаар морьт дивизийг командалсан хошууч генерал Ч.Доржпалам дурсан "Цагаан хэрэмд орох цорын ганц зам дээр нөхөр Б.Дэмчигийн тушаалаар пулемёт зоож, хориглолт байгуулжээ. Энэ нь дайсан бууж өгөх нэг чухал нөхцөл болсон юм" гэж өгүүлжээ. Губэйкоу хотыг чөлөөлсний дараа хорооны дарга, хошууч Жамбал хотын төмөр замын цаана байрлах тосгонд байгаа Японы тасаг цэргийг буулган авах зорилгоор 32 цэргийн бүрэлдэхүүнтэй отряд байгуулан даргаар нь 14 морьт хорооны 2 дугаар сумангийн дарга, дэслэгч Б.Дэмчигийг томилон явуулжээ. Тухайн үед бороо их орж, гол үертэй байсан ч дэслэгч Б.Дэмчиг голыг амжилттай гаталж, дайсныг бууж өгөхийг шаардсан боловч шаардлагыг биелүүлэхгүй тул отрядда дөрвөн хэсэгт хуваан тосгоныг бүсэлж, удаан хугацаагаар тэвчээртэй шаардаж, элдвээр сүрдүүлсээр буулган авч байлдааны үүргийг гарамгай биелүүлжээ.

### Долоннуур, Жэхэгийн чиглэлд давшсан МАХЦ-ийн нэгтгэл, ангиуд

Байгаль, цаг уурын нэн хүнд нөхцөлд 1000 гаруй км-ийн хол замд 9-10 хоногийн хугацаанд байлдааны үүрэг гүйцэтгэж эх орныхоо даалгаврыг нэр төртэй биелүүлэхэд 14 дүгээр морьт хорооны 2 дугаар суман идэвхтэй оролцож, залуу дэслэгч Б.Дэмчиг салбарын байлдааны ажиллагааг сайн зохион байгуулдаг, чадварлаг, эр зоригтой дайчин дарга, улс төрийн ажилтан гэдгээ харуулж чаджээ.

Дэслэгч Б.Дэмчиг дайны төгсгөлд Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Дамдинхүү, Улс төрийн газрын орлогч дарга, хошууч генерал С.Равдан нараас

байгуулжээ.

Дайны ялалтыг байгуулахад баатарлаг гавьяа байгуулсан МАХЦ-ийн дайчдаас 302 хүнийг Зөвлөлт Засгийн газраас шагнасны дотор "Улаан таван хошуу" одон хүртсэн таван хүний нэг нь сумангийн дарга, дэслэгч Б.Дэмчиг байлаа. Мөн 1971 онд МАА-ийн 50 жилийн ойг өргөн тэмдэглэх үеэр бүтээсэн "Монголын Ардын Армийн 50 жил" цомогт "1945 оны Чөлөөлөх дайнд байлдааны үүргийг гарамгай биелүүлсэн зарим хүмүүс" гэсэн хэсэгт багтсан 32 хүний нэг нь тэр бөгөөд түүнийг баатрын энтэй офицер байсныг харуулдаг. Цэргийн албанд үүрэг гүйцэтгэх 10 гаруйхан жилийн хугацаанд "Байлдааны гавьяаны улаан тугийн одон", "Август-Халх гол", "Бид ялав", ЗХУ-ын "Улаан таван хошуу" одон, Зөвлөлтийн "Бид ялав", "Байлдааны медаль" зэрэг төрийн одон, медаль хүртсэн нь Б.Дэмчигийн эр зориг, баатарлаг үйлсийн илрэл гэлтэй.

### Энхийн бүтээн байгуулалтад зүтгэсэн нь

Б.Дэмчиг 1947 оны 11 дүгээр сард цэргээс бэлтгэлээр халагдан Чойбалсан аймгийн "Дөл" сонины газарт хянагч, аж ахуйн эрхлэгч, 1948 оны 3 дугаар сараас 1951 оны 7 дугаар сар хүртэл аймгийн Намын хорооны зааварлагч, дарга нарын туслахаар ажиллажээ. Тэрээр 1951-1954 онд Намын дээд сургуульд суралцаж, 1954-1962 онд Баянхонгор, Төв аймгийн Намын хорооны хэлтсийн дарга, Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлийн зөвлөлийн зааварлагч, 1962-1966 онд Завхан аймгийн Жавхлант сумын "35 жил" нэгдлийн намын үүрийн дарга, 1966-1967 онд Барилгын яамны Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны даргаар ажиллаж байгаад хүйтэн дайны хүнд жилүүд эхлэхэд армидаа эргэн ирсэн юм. Тэрээр улс орныхоо хөгжлийн эгзэгтэй хүнд үед намын ажлын тэргүүн шугаманд ажиллаж, өнөөгийн Дорнод аймгийн "Дөл" сонины ажил үйлчилгээг төлөвшүүлэх, бүх нийтийг бичиг үсэгтэй болгох, гэгээрүүлэх, эрүүлжүүлэх, хөдөө аж ахуйг хоршоолох, атрыг эзэмших нэгдүгээр аяныг хэрэгжүүлэхэд нэгэн насны хөдөлмөрөө зориулан, соёлын довтолгооны гурван шатыг даван туулсан намын удирдах ажилтан байлаа. Тэр бээр 1967-1977 онд Ардын Армийн Барилгын цэргийн 110, 048, 158, 164 дүгээр

тэр үеийн ханшаар 24 сая 755 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 65 барилга байгууламжийг төлөвлөгөөт хугацаанаас нь нэг жилийн өмнө ашиглалтад оруулжээ. Ийм хэмжээний нүсэр ажлыг шинэ тутам байгуулагдсан анги, шинэ цэрэг, шинэ хамт олноор шахуу төлөвлөгдсөн хугацаанаас нь нэг жилийн өмнө амжилттай дуусгана гэдэг хэн хүний хүслээр болчих зүйл биш нь маргашгүй үнэн. Энэ бол "Барилгын ажлын удирдлага зохион байгуулалтын болон барилгачидтай ажиллах арга барилын асар их туршлагатай дарга, хурандаа Г.Осор, дайны галын дунд ч, энхийн бүтээн байгуулалтын талбарт ч цэрэг, ажилтан албан хаагчдын дунд нам улс төрийн ажлыг бүтээлч арга барилаар чадамгай зохион байгуулан, тэдний идэвх санаачилга, бүтээлч зүтгэл, урам зоригийг дэмжиж, урамшуулан ангийн төлөвлөгөөт даалгаврыг биелүүлэх сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлж чаддаг намын хорооны дарга, хошууч Б.Дэмчиг нарын ажлын шууд үр дүн байлаа" гэж Барилгын цэргийн ахмад ажилтан, хурандаа О.Ашгай дурсжээ.

1970 оноос барилгын тээвэр-механизмын 048 дүгээр анги нь 164 дүгээр анги болон өргөжиж хошууч Б.Дэмчиг Намын хорооны даргаар томилогджээ. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн 1971 оны XXV чуулганаар батлагдсан "Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнуудын социалист интеграцийн хөгжил, хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэн боловсронгуй болгох иж бүрэн хөтөлбөр"-т тусгагдсан бүтээн байгуулалтын ажил улс орон даяар эхэлж, Герман улсын эзэлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Мах комбинатын өргөтгөл-шинэтгэл, Хивсний үйлдвэр, Чехословак улсын хөрөнгө оруулалтаар Дархан хотын Цементайн зовад, Улаанбаатар хотын Гутлын үйлдвэр, Баатар улсын хөрөнгө оруулалт, техник технологийн болон мэргэжилтний туслалцаагаар Дарханы Нэхий дээлийн үйлдвэр, Дорнод аймгийн төвд Мах комбинат, Орхон-Шарын голын жимс-ногооны сангийн аж ахуй, Унгар улсын эзэл, техник, технологи, мэргэжилтний туслалцаатайгаар Сонгино дахь биокмбинат, Улаанбаатарын Оёдлын үйлдвэр зэрэг олон бүтээн байгуулалтыг Барилгын

түүнээс хойш Д.Түмэн, Г.Очирбат нар Хөдөлмөрийн баатар цол хүртэж, жолооч Д.Очирбат Гавьяат тээвэрчин алдарт хүрсэн нь Б.Дэмчигийн нөр их зүтгэл, шаргуу уйгагүй ажлын илрэл болсон билээ.

БНМАУ-ын шинэ хөгжийн их бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмэр, гавьяа, зүтгэлийг нь төр, засаг, Армийн командлалаас үнэлж Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн алдар, Сүхбаатарын одон, "Алтан гадас" одон, Ардын хувьсгалын болон Ардын Арми, Хилийн цэрэг, Г.К.Жуковын ойн медалиуд, "БХЯ-ны хүндэт тэмдэг", "Тэргүүний барилгачин", "Онц тээвэрчин", "Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч" зэрэг төр, засаг, олон нийтийн байгууллагуудын шагналуудыг хүртэсэнээс энхийн цагт "БНМАУ-ын хөдөлмөрийн баатар"-ын энтэй хөдөлмөр зүтгэл гаргасан нь тодорхой харагдана.

Улс, эх орныхоо төлөө зүтгэнэ гэж юу байдгийг үлгэрлэсэн Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, дэд хурандаа Б.Дэмчигийн амьдралын түүхэн замнал бахархуштай. Тэр бээр үнэхээр гайхалтай хөдөлмөрч, нийгмийн хөгжлийн цаг үеийг мэдэрдэг сайн зохион байгуулагч, удирдагч, нийгмийн амьдралд идэвхтэй оролцогч байсан нь 1990 оны өөрчлөлт шинэчлэлийн зөв бурууд дүгнэлт хийж, дайнд оролцсон ахмад дайчдын амьдрал, хувь заяа хүнд болсон үед 1997 оны Олон улсын Ахмадын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид илгээсэн "Ил захидал"-аар нотлогдож байна. Уг захидлын зохиогч бөгөөд 1939, 1945 оны дайнд оролцсон таван нөхдийн хамт гарын үсэг зуран Ерөнхийлөгчийн гарт өгч, "Соёмбо" сонинд нийтлүүлсэн нь ахмадуудын талаар төр, засгаас авч буй өнөөдрийн арга хэмжээнүүдийг зааж, чиглүүлж өгсөн юм уу гэлтэй. Захидлын агуулга, тавигдсан зургаан санал бүгд хэрэгжсэн нь алсыг харсан, бодитой шийдвэр гаргаж чадаж байсныг харуулна. Дашрамд тэмдэглэхэд төрсөн нутаг Завхан аймгийн Цагаанхайрхан суманд нь түүний алдрыг мөнхжүүлж, хүндэтгэлийн талбай, цэцэрлэг тохижуулбал хүүхэд, залуусыг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлж, төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол цэргийн музейн ахмад ажилтан, судлаач М.БЯМБАРАГЧАА



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЗЦК-ААС МЭДЭЭЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын "Холбооны гурав"-ыг энэ удаагийн дугаартаа онцолж байна. Тогтуун тайван араншин, хүлээцтэй байдлаараа хоорондоо тун чиг адилхан холбоочин офицеруудын өрөөгөөр нь ажил эхлэхтэй зэрэгцээд орлоо. Нэлээд олон техник дэлгэчихсэн сууж байна. Энэ нь даргын зөвлөлийн өрөө болон Оперативын шуурхай удирдлагын төвд суурилуулах хурлын төхөөрөмж гэнэ. Тэдэндэнэ өдөр төхөөрөмжийг суурилуулахаас гадна шинээр томилогдсон алба хаагчдын өрөөг утсан холбоо, дотоод сүлжээнд холбох, ЗХЖШ болон командлалын нэгтгэл, ангиудаас цахимаар



# ХОЛБООНЫ ГУРАВ

ирж байгаа шийдвэр, мэдээлэл, судалгааг цаг бүрд нь холбогдох албан тушаалтнуудад дотоод сүлжээгээр тараах гээд өдөр тутамдаа гүйцэтгэдэг нэлээдгүй олон ажил байгаа аж. Хуурай замын цэргийн командлал Төв аймагт шилжин байрласнаас хойш холбоочдын үүрэг хариуцлага тун их нэмэгдсэн нь тодорхой байв. Техник хэрэгсэл суурилуулах, холбох, дамжуулах, засварлах ажил хаана байна, тэнд л холбооны гурав маань гүйж явна. Энэ тухай холбооны дарга, хурандаа Ч.Оточсүрэн "Холбоочин, тэр дундаа цэргийн холбоочин гэдэг хамгийн сайхан мэргэжил. Зэвсэгт хүчний бүх төрөл мэргэжилтэй холбогддог, зангилаа нь болж байдаг учраас мэргэжлээрээ үргэлж бахархаж, хийж гүйцэтгэсэн ажил, үүргээсээ урам зориг авдаг. Манай мэргэжилтнүүд ч ялгаагүй" хэмээн мэргэжлээрээ бахархан яриагаа эхлүүлэв. Хурандаа Ч.Оточсүрэнгийн хэлснээр Хуурай замын цэргийн командлалын энэхүү том барилгыг холбоожуулах ажил хоёр үе шаттайгаар явагдаж байгаа ажээ. Эхний шатанд техник, тоног төхөөрөмжийг татан авах, бэлэн байдлыг хангаж, тэдгээрт гарсан гэмтлийг шуурхай засварлах, бүх өрөөг утсан холбоо болон дотоод сүлжээнд холбох, шаардлагатай цөөн тооны албан тушаалтанд интернэт суурилуулж өгөх, камержуулах, сургалтын өрөө, тасалгаануудыг зэрэг төхөөрөмжлөх ажилыг холбоочид зохион байгуулсан байна. Харин цаашдаа командлалын дотоод сүлжээг стандартын дагуу илүү хүчирхэг болгох, холбооны зангилааг дэлгэн байгуулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр нөхөн хангуулах зэрэг хэд хэдэн зорилгыг дэвшүүлжээ. Зарим нь ч эхнээсээ хэрэгжих шатандаа орсон гэнэ. Командлалын дотоод сүлжээг ЗХЖШ-тай холбох ажил ирэх намар гэхэд бүрэн шийдвэрлэгдэнэ. Мэдээж энэ тийм ч амар ажил биш бөгөөд ЗХЖШ-тай шууд холбогдохын тулд бие даасан шугамтай болох шаардлагатай гэнэ. Холбоочид өдөр тутмынхаа үйл ажиллагаанаас гадна харьяа нэгтгэл, ангиудынхаа холбооны системийн бэлэн байдал, тэдгээрт гарсан гэмтлийг шуурхай засварлуулах, зөвлөгөө өгөх, гарын авлага, материал, техник хэрэгсэлээр хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах, шаардлагатай тохиолдолд дээд байгууллага буюу ЗХЖШ-ын Удирдлага холбоо, мэдээллийн аюулгүй байдлын хэлтэст хандах зэрэг ажлыг шат дараатай хийж гүйцэтгэдэг байна. Ч.Оточсүрэн хурандаагаас баримталдаг зарчмыг нь сонирхоход "Бидний залгамж халаа бол залуу үе юм. Би ч гэсэн залуудаа чадалтай эрдэмтэн багш, холбоочдынхоо зааж сургасан

эрдмээр энэхүү мэргэжилд дурласан хүн. Тэр утгаараа залуу үеийнхэндээ өөрийн мэддэг бүхнээ заагаад өгчих юм сан гэж зорьж явдаг. Хээрийн сургуулиуд болоод нэгтгэл, ангиудаар шалгалтаар явахдаа ч холбооныхоо офицер, ахлагч нарт зөвлөгөө өгч, мэргэжилдээ эзэн нь болж манлайлж явах урмын үгийг харамгүй хэлдэг" гэлээ. Ажил, мэргэжлээрээ бахархаж явдаг хурандаа маань Зэвсэгт хүчинд 23 жил алба хааж байгаа аж. БХИС-ийг 2001 онд Холбооны команд тактикийн офицер болон радио холбооны инженер мэргэжлээр төгсөж, Зэвсэгт хүчний 189 дүгээр ангид ээлжийн дарга, техникчээр ажлын гараагаа эхлүүлсэн байна. Үүний дараа 2005-2007 онд Зэвсэгт хүчний 015 дугаар ангид Холбоо дохиоллын албаны дарга, 2007-2011 онд Зэвсэгт хүчний 256 дугаар ангид Холбооны даргаар ажиллаад 2011-2013 онд Батлан хамгаалахын, удирдлагын академид суралцаж төгссөн байна. Тэрээр 2013-2018 онд ЗХЖШ-ын Удирдлага холбооны хэлтэст мэргэжилтнээс ахлах мэргэжилтэн, албаны дарга болтлоо дэвшсэн бол өмнө нь ажлын гараагаа эхэлж байсан Зэвсэгт хүчний 189 дүгээр ангид 2018 онд Засварын төвийн даргаар томилогдон ажиллаж байгаад тэр жилдээ Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд холбооны даргаар томилогдсон нь энэ ажээ. Тэр эхнэр, дөрвөн охины хамт амьдардаг. Түүний гэргий Б.Очирсүрэн Цэргийн төв эмнэлгийн лабораторид их эмчээр ажилладаг. "Таны тайван дөлгөөн байдгийн цаад шалтгаан охидтой чинь холбоотой юу" хэмээхэд инээснээ "Магадгүй. Ер нь бол аливаа асуудлыг тайвнаар чанартай хийж гүйцэтгэхийг урьтал болгодог" гэв. Тэрээр Хуурай замын цэргийн командлал, түүний байдал, ангиудад холбооны чиглэлээр хийж хэрэгжүүлэх олон ажлыг төлөвлөж буйгаа ярилцлагынхаа төгсгөлд дуулгаад манай командлалынхан гар нийлэмжтэй сайхан хамт олон доо хэмээн журмын нөхдөө магтлаа.

Х у р а н д а а г и й н цэргүүдийг хошууч Д.Мөнхбаатар, хошууч Г.Мөнхтүвшин гэдэг. Хошууч Д.Мөнхбаатарын хувьд нууц, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, холбогдох албан тушаалтнуудад дамжуулах үүрэг гүйцэтгэдэг. Түүний гүйцэтгэдэг үүрэг, эрхэмдэг албан тушаалыг үүнээс цааш дэлгэрэнгүй бичих шаардлагагүй. Тэрээр ахлагчийн эгнээнээс офицерын эгнээнд шилжсэн нэгэн. БХИС-ийн Ахлагчийн

сургуульд 1996-1997 онд суралцаж төгсөөд Зэвсэгт хүчний 124 дүгээр ангиас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд ахлагчаар 11 жил ажиллажээ. 2002-2006 онд БХИС-ийн Удирдлага, технологийн сургуульд суралцаж эрх зүйч мэргэжлээр төгссөнөөс хойш гурван жилийн дараа офицерын эгнээнд шилжсэн байна. Мэдээж түүний туршлага арвин. Зэвсэгт хүчний 124 дүгээр анги, ЗХЖШ, Зэвсэгт хүчний 016 дугаар бригад, 065 дугаар ангид шат дараатай ажил албыг хариуцаж байгаад 2017 оноос Хуурай замын цэргийн командлалд томилогдсон байна. Түүний эрхэмлэдэг зан чанар нь "Ажил албандаа чин сэтгэлээсээ хандаж, итгэлийг зүтгэлээр хариулах. Түүний хань мөн адил мөрдэс зүүсэн цэргийн бүсгүй бөгөөд Зэвсэгт хүчний 124 дүгээр ангид алба хаадаг, ахлагч Х.Мөнгөнчимэг аж. Тэд хоёр охин, нэг хүүтэй. Том охин нь ҮБХИС-д суралцдаг бол удаах хоёр нь дунд сургуулийн сурагчид. Түүнтэй ийнхүү хөөрөлдөөд суух зуур гаднаас "Бичиг явуулсан, ангиуд руу илгээнэ үү" гээд хэд хэдэн офицер, ахлагч нар ээлж дараалан орж ирэх нь хэр завгүй ажиллагчийг нь нотлон харуулж байв. Тийм нэг аядуу зөөлөн мөртлөө ажилсаг хүн байдаг даа. Тэр яг л тийм хүн ажээ.

Дараагийн онцлох эрхэм бол мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч Г.Мөнхтүвшин. Хаана олон улсын сургууль, хамтарсан сургууль, сургалт дадлага болно, тэнд л Мөөгий хошууч гүйж л явдаг. "Хааны эрэлд" олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургууль, "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан, "Сэлэнгэ" тактикийн хээрийн сургуулиас эхлээд олон ч ажил, арга хэмжээний холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцан зогсож байдаг залуу. Түүнийг командлалынхан "Завгүй Мөөгий" гэнэ. Учир нь тоног төхөөрөмж залгах, салгах, эвдрэл, гэмтлийг засварлах, сүлжээ холбох, командлалын нэгтгэл, ангиудын мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах зэрэг холбоо, мэдээллийн нарийн чимхлүүр ажил өдөр тутамд их гардаг учраас тэрээр завгүй өнждөг нь хэнд ч нүднээ илхэн. Тэрээр 2007 онд БХИС-ийг Ерөнхий цэрэг командын мэргэжлээр төгсөөд Зэвсэгт хүчний 013, 189 дүгээр ангид алба хааж, 2019 оны 10 дугаар сард тус командлалд томилогджээ.

Ийнхүү командлал, түүний нэгтгэл, ангиудын холбооны ард хэзээд бат зогсох офицеруудын тухай төсөрхөн өгүүлэхэд ийм буюу.

Ахлах дэслэгч  
Д.БОЛОРМАА

## АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЦЭРГИЙН АКАДЕМИ

"West Point"-ын цэргийн академи нь 1802 онд АНУ-ын хамгийн анхны цэргийн академи болж Нью-Йоркод байгуулагдсан. Уг академийг төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар нь дайн, байлдаануудын үед (Мексик-Америкийн дайн, Америкийн иргэний дайн, Дэлхийн 1, 2 дугаар дайн, Вьетнамын дайн) маш өндөрөөр үнэлэгдэж дэлхий дахинд танигдсан. Иймд тус академид суралцах хүсэлтэй залуус маш их байдаг. Энэ шалтгаанаар академийн элсэлтийн сонгон шалгаруулалт нь

даалгаврыг хоёр цаг хийх үүрэгтэй. Иймд ихэнх сонсогч шөнийн хоёр цаг хүртэл хичээлээ давтдаг. Энэ нь сонсогчдыг цагийн зөв хуваарилалт, тэсвэр хатуужилд сургах үндсэн зорилготой юм. Сонсогчдын биеийн тамир, зан харилцааны төлөвшилт, цэргийн мэдлэг, мэргэжлийн хичээлийг байнга шалгаж дүгнэдэг. Хэрэв дээр дурдсан шалгалтын төрлүүдээс аль нэг бүлэг дээр хангалтгүй гэж үнэлэгдвэл чөлөөгөө хасуулах, улиран суралцах, бүр суралцах эрхийг нь хасах хүртэл шийтгэл



өндөр шалгууртай, өрсөлдөөнтэй явагддаг. Тухайлбал, академид элсэгчид 17-23 настай, гэрлээгүй, хүүхэдгүй байх ёстой.

Монгол Улсаас тус академид суралцах оюутныг Батлан хамгаалах яам болон АНУ-ын Элчин сайдын яам хамтран сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр сонгодог. Уг сонгон шалгаруулалт нь биеийн тамирын шалгалт, АНУ-ын ерөнхий боловсролын шалгалт (SAT), англи хэлний түвшин тогтоох шалгалт (TOEFL), ярилцлага гэсэн хэсгүүдээс бүрддэг юм. Дээрх шалгалтад тэнцсэн тохиолдолд Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын тушаалаар тус академид суралцахаар томилогддог.

АНУ-ын Цэргийн академид суралцаж байгаа нийт сонсогчдын нэг хувь нь гадаад улсаас буюу 10-17 орноос ирсэн байдаг. Тус академид жилд дунджаар 1300 гаруй сонсогч 45 академик мэргэжлээр суралцахаар элсдэг. Шинэ сонсогч нар 6 дугаар сард ирж 42 хоногийн хугацаатай цэргийн анхан шатны бэлтгэл, сургалтад хамрагддаг. Уг сургалт дууссаны дараа академийн хичээлийн жил эхэлнэ.

оноодог. Эдгээр хүнд шалгуурыг нийт элсэгчдийн 90 хүрэхгүй хувь нь давж бакалаврын зэрэгтэй, АНУ-ын Зэвсэгт хүчинд таван жил ажиллах гэрээтэй, дэслэгч цолтой төгсдөг.

Сонсогч бүр 6 дугаар сард хээрийн дадлагад хамрагдаж тухайн жилдээ суралцсан тактик, удирдан зохион байгуулах чадвараа практик дээр хэрэгжүүлж дадлагаддаг. Мөн АНУ-ын Армийн шүхэрчний курс (Airborne Course), байлдааны шумбагчийн курс (Combat Diver Course), ширэнгэн ойн сургууль (Jungle School), сапёрчны сургууль (Sapper School) болон Их Британи, Франц улсын тусгай сургалтад хамрагдах боломжтой. Эдгээр тусгай сургалтад хамрагдахын тулд тухайн сургалттай холбогдох шалгалтуудад тэнцсэн байх шаардлагатай.

Хээрийн дадлагын агуулгыг курс тус бүрээр нь товч дурдвал:

-Нэгдүгээр курс: Цэргийн анхан шатны бэлтгэл (42 хоног);

-хоёрдугаар курс: Баг удирдах аргачлал болон тактик (21 хоног);

-гуравдугаар курс: Тасаг удирдах аргачлал болон тактик (21 хоног);



Академийн бүтцийн хувьд дөрвөн хороо, 12 батальон, 36 ротос бүрддэг. Өдөр тутмын үйл ажиллагааг тусгай томилогдсон офицерууд, харин ротын өдөр тутмын үйл ажиллагааг төгсөх курсийн болон гуравдугаар курсийн сонсогчид удирдан зохион байгуулах чадварыг хөгжүүлэх дадлага ойлгогтой.

06:50 Өглөөний жагсаал  
07:30 Эхний хичээл  
11:30 Өдрийн хоол  
12:35 Хичээл  
16:00 Хичээл дуусна  
16:20 Спорт клуб  
18:30 Оройн хоол  
23:30 Амрах команд  
Өдөрт дунджаар 5-7 хичээл орох ба хичээл тус бүрийн

-дөрөвдүгээр курс: Салаа удирдах аргачлал болон тактик (14 хоног) тус тус явагддаг. Гурав болон дөрөвдүгээр курсийн сонсогчид зуны хээрийн дадлага дууссаны дараа Сонсогчийн удирдах чадварыг хөгжүүлэх дадлага (CLDT) буюу илүү хүндрүүлсэн хээрийн дадлагад мөн хамрагддаг. Энэ дадлага нь АНУ-ын ренжерийн сургуулиас жишээ авч хөгжүүлэгдсэн учир сонсогч бүрийг хоол, нойргүй хүндрүүлсэн нөхцөлд салаа удирдан зохион байгуулах чадварт сурган дадлагажуулдаг юм.

Монгол Улсаас 2020 оны байдлаар тус академийг дөрвөн сонсогч амжилттай суралцаж төгссөн бөгөөд одоогийн байдлаар хоёр сонсогч нэг болон гуравдугаар курсэд суралцаж байна.

Дэслэгч М.АРИУНБОЛД

# ЭХ ОРОНЧ ЧЭЭЛ НЭВТЛ ШИНТЭСЭН МОНГОЛ НАЙРАГ

**ЯРУУ НАЙРАГЧДЫН СОНГОДОГ  
БАДГУУДЫГ УНШИЖ, БОДОЖ  
БЯСАЛГАХЫН УЧИР**  
**“Соёмбо” (“Улаан Од”,  
“Тусгаар тогтнол”) сонин  
үүсэн байгуулагдсан цагаасаа  
л цэрэг эр, яруу найраг хоёрын  
алхааг жигдэлж, сэтгэл зүрхээр  
нь ханьсуулж, сайхан шүлэг  
уншаад хөөрч догдолдог,  
бодож эргэцүүлдэг түм түмэн  
уншигчдыг араасаа дагуулж  
байсан гайхамшигт түүх  
цадигтай хэвлэлүүдийн нэг юм.  
Одоо ч энэхүү уламжлалаа нэр  
төртэй үргэлжлүүлж байгаад  
жирийн уншигч бид талархаж  
явдаа илэрхийлье.**

“Хэнтий, Хангай, Соёны өндөр сайхан нуруудтай, Мэнэн, Шарга, Номинь өргөн их говиудтай, Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнуудтай, Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүдтэй, Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нууруудтай, Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээртэй, Дөрвөн цагийн улиралд дураар нүүх нутагтай” хэмээн Миний нутаг-Монголын сайхан орноо зурагласан их зохиолч Д.Нацагдоржийн найраглалыг монгол хүн бараг л хэлд орсон цагаасаа эхлэн цээжээрээ уншиж, төрж өссөн нутаг, эх орноороо бахархаж, хөөрөх зүрх сэтгэлийн дуудлагатай болдог билээ.

Дэлхийн 28 оронд түгэж уншигдаад байгаа Америкийн судлаач, нийгмийн антропологич Жак Уэтерфордийн бичсэн “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” номыг монгол хэлээр 2011 онд орчуулан хэвлүүлснийг манай цэргийнхэн уншаад арваад жилийн нүүр үзэх нь. Зохиогч энэхүү номынхоо оршилд “Дорнод Европт монголчууд Славяны арав гаруй вант улс, хотуудыг Орос оронд нийлүүлсэн. Зүүн Азид зүүн талаараа Манжуур дахь Зүрчидийн нутаг, баруун талаараа Төвөд болон говьтой хил залган Тангуд улсыг, зүүн Туркестаны Уйгарын нутагтай Сүн улсын үлдэгдлийг нэгтгэн гурван үеийн туршид Хятад улсыг эмхлэн байгуулсан юм. Монголчууд эзэмшил нутгаа тэлж өргөжүүлэхийн хэрээр тэдний тогтоосон хил хязгаарыг орчин цагт бараг тэр хэвээр нь хадгалж хоцорсон Солонгос, Энэтхэг улс үүссэн” гэж орчин цагийн даяаршлын эхлэлийг тавьсан 700-гаад жилийн өмнөх Монгол гүрний дэлхий нийтийн түүхэнд оруулсан гавьяа, ул мөрийг тодотгожээ. Оросын түүхч Лев Николаевич Гумилев XII-XIII зууны эрч хүчтэй, авхаалж самбаатай, тэсвэр хатуужилтай, эр зоригтой монголчуудыг тухайн эрин цагийнх нь байгалиас заяасан пассионар тэсрэлт төрүүлсэн юм гэсэн дүгнэлт хийж, Чингисийн эзэнт гүрний угсаатны онцлогийг олон талаар үндэслэжээ. Ардын уран зохиолч Д.Пүрэвдорж 1960-аад онд бичээд 1990-ээд он хүртэл хориотой байж нийтийн хүртээл болж чадаагүй “Чингис” шүлэг “Тэмүүжин нумын хөвчнөөс төрөөгүй Тэмүүжин сумын зэвээс гараагүй Тэмүүжин Өэлүн эхээс төрсөн юм Тэмүүжин өрлөг түүхээс гарсан юм” гэж эхлээд Эзэн Чингис хааны байлдан дагуулалт өрнө, дорныг худалдаа арилжаа, зам, тэвээр, соёл, иргэншлийн солилцоогоор холбож буй өнөөгийн даяаршиж байгаа ертөнцийн эхлэлийг тавьсан юм гэж нотолсон Жак Уэтерфордын санааг хуваалцсан юм шиг гайхамшигт мөрүүдээ бичсэн байдаг.

**“Хөх Монголын дэвээн тэнгисийн шуургыг ярж Хөмхий зуусан ертөнц Чингисийн өмнө сөхөрсөн юм Хүлэг морьдын туурай өрнө, дорныг цөмлөж, Хөл нүцгэн хорвоо халуун нурам гишгэснийг” бахархан шүлэглэж “Ямар ч байсан Чингис хангарьд шиг хальж Ял, гавьяа хоёроо хойч үедээ даатгасан юм Гал усанд элэгдсэн буурал замбуутивийн магнайд Ган сэлмийнхээ ирээр Монгол гэж бичсэн юм”** хэмээх үр хойчдоо үлдсэн 1206 онд Их Монгол улсаа эмхлэн байгуулж, Монголын түүхийн алтан үеийг эхлүүлсэн их хааныхаа алдар гавьяаг ухааран дэнсэлж, бахархаж бишрэх өнөө үеийнхний омог зоригийг хөвчилсөн билээ.

1960-аад оны сүүлчээс бидний үеийн өнөөгийн 70 гаруй насныхан залуу, өсвөр ахуйдаа Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ” найраглалыг үндэслэг, цэнгүүний тайзнаас олонтоо уншиж, ямар эх оронд төрж, өсөж байгаагаа сэтгэлийн гүнээс ухааран сэнхэрч байгаагаа илэрхийлдэг байлаа.

**“Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт**

**Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд Хоёр нүдний үзүүрт цэнхэрлэх тедий тэртээд ... Авхаалжит хүний биеийг эзэгнэнхэн төрсөн” монгол хүн би Амь нэгтэй олныхоо Монголоо гэсэн сэтгэлд ... Цээл сайхан эгшигтэй уртын дууны аянд Цэнгэх, зовох хосолсон хүний хувь заяанд ... Хүчирхэг дээдсийн нутагт мандсан хувьсгалын дөлөнд Хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн амьдрах”** заяа тавилантай байжээ.

1960-аад оны сүүлчээр Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгээр хөдөө нутгийн сумдын наадмын дуу хуур цалгидаг байлаа.

Шандаст хурдан хүлгээ уралдуулж, алтан тоосоо өргөж түрүүлсэн морьдынхоо цол юуг нь дуудаж, айраг цагаагаар магнай юугий нь мялааж байгаа хүдэр чийрэг эрс, тухайн цагийн дугуй хэвтээр гоёсон охид, хүүхнүүд наадмын талбайн радиотой хөг нийлүүлэн

**“Нүүрэнд нь гал бадарсан Монгол эцгийн хийморь дээр Нүнжигт нь нар гэрэлтсэн Монгол эхийн сэтгэл дээр Нүүдлийн өргөөнд нэгдсэн Монгол аймгийн холбоон дээр НҮБ-ын шилтгээнд заларсан Монгол Улсын далбаан дээр Тусгаар тогтнол чамайг Тунхаглан бичнэ би”** хэмээн уншиж туурга тусгаар орныхоо хүн ардын дэвэрч хөөрсөн сэтгэлээр долгиолж, монгол түмнийхээ их баяр наадмын учир утгыг тайлдаг байлаа.

**Санаа алдахад Эхийн сүү тагнайд амтагдаж Салхны нь үзүүрийг залгихад Агь хоолойд аргасан** Боржигоны бор талд төрж өссөн Ардын уран зохиолч Б.Лхавгасүрэн **Надин эрхэмсэг, эгэл боргилын туйл Нар хур царайчилсан газрын саальтай хормой** болдог Боржигоны бор талаасаа хүний ухааныг олж, монгол түмнийхээ хайр хүндэтгэлийг хүлээсэн найрагч болсноо ийн шүлэглэжээ.

**Жаргал зовлон хоёрыг амсаж, эдэлж Чулуун дээр чинь баяр гунигийн нулимс унагаахад Эр шиг нуруутай бай гэсэн шиг Эргүүлж над руу цацан хатуугаас хатуу байсан чи ... Нутаг усны минь хаяа өлзийтэй түмэн Нуур тойрмын ширхэг чулуу хүртэл**

**Намайг хүн болгосон Байдуу мянгань уулсаа дуурайн Толгойд буурал сууж Багадаа хөхсөн эхийн сүү Гадагшлахын цагт Шүлгээ би чам дээрээ Хүн чулуу шиг орхиод Сүүдрээ дарж унахдаа Элгийг чинь цөмлөн шингэнэ,** Боржигоны бор тал минь” гэж төрсөн газар шороо, тал нутагтаа өргөх тангаргийн үгээ хэлж, эх нутаг, хүн хоёрын хүйн холбоотойг найргийн яруу сонсголонт хэлээр илэрхийлсэн билээ.

Дэлхийн аль ч улс оронд ховорхон тохиолддог улирлын ээлж дараалах он цагийн жамаар монгол хүн бахархаж, хөөрч догдолдог. Өөр хоорондоо хурц тод өнгөөрөө, уур амьсгал, ургамал цэцэгсээрээ эрс ондоо ялгарахуйц жилийн дөрвөн улирал манай цэцэн билигт яруу найрагчдын урлахуйн эрдэм ухааныг ундраадаг. Унаган байгалийнхаа төгс төгөлдөр гоо сайхныг сэргэж мэдрэх, сэхээрч ухаарах, хайрлаж хямгадах удмын монгол ухаан яруу найрагчдад маань заяажээ. Шилмэл найрагчдын минь урлахуйн гайхамшигийг сэтгэл зүрхнээс нь өдөөж, сэрээсэн говь хангай, тал хээр хосолсон уудам дэлгэр эх нутагт минь айлчлан ирдэг дөрвөн улирлын тухай яруу найргийн мөрүүдийг монгол хүн ухаан санааныхаа угт “Элэг зүрхнээс уяатай, Энхрий монгол нутаг минь” гэсэн шившлэгтэйгээр сэтгэл хөөрөн уншдаг. Их зохиолч Д.Нацагдоржийн “Дөрвөн улирал”-ыг залгаад л Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” монгол хүний сэтгэлийн ахуйд амар амгалан, тайвшралын гэгээ цацруулж, төрөлх монгол ахуйн минь эгэл энгийн мөртлөө агуу уужим, түмэн өнгө, аясыг зурагладаг.

**“Хөх лонхон тогоруу дуугарах сайхан Хөдөө цайдам борооших сайхан Анирхан ахуйд цэцэг дохих сайхан Аадрын өмнөх байдал сайхан ...”** “Тооноор цас будран орох нь

**сайхан Тогооны таган дээр унаад хайлах нь сайхан Гэрийн хойморт аав суух нь сайхан Гэрэлтэй үүдээр ээж орж ирэх сайхан ...”** “Толгодын орой зэрэглээтэй сайхан Торгон салхи сэвэлзэх сайхан Хөх ногооны униар татах сайхан Хөх мананд ороолгон суух сайхан ...” “Дэлхийн чулуунд хяруу цавцайх сайхан Дэрсээр дээр нь шүлэг бичих сайхан Дээвэр дэвэх салхинд сэтгэл гэгэлзэх нь сайхан Дэндүү ойрын хайраас холд байх нь сайхан ...”

гээд л хөдөө талын яруу найрагч улирал, цагийнхаа өнгө, хүн зоньхоо ахуй амьдралыг эгэл жирийнээр зураглаж амар амгалангийн гэрэлт мөрүүдээ бичсэн байдаг. Монгол эрт урьдаасаа л хэрүүл хараалгүй, сөргөлдөөн тэмцэлгүй, атаа шуналгүй, бие биеийнхээ сэтгэлийг ерөөлийн сүү, хадгаар мялаасан амар амгалан амьдралдаа сэтгэл өөг байж сурч дадсан ард түмэн юм. Төрийн шагналт яруу найрагч Ц.Бавуудорж “Монголын их амар амгалан” шүлгээ их хотын шуугианд дөжирч, бухимдаж, адгаж явдаг бидний сэтгэлийн ахуйд минь зул асааж, оюун санаанд минь амар тайвны гэрэл гэгээ цацахаар бичсэн юм шиг санагдах нь бий.

**“Эрдэнийн сормуусаа униарт дүрж адуу унтах Монголын их амар амгалан Эр хүн ятгатай дуулах Монголын их амар амгалан ... Ганган харцтай бүсгүйчүүд Монголын их амар амгалан Жаргаж гуних Монголын их амар амгалан Зангирсан нулимс дотогшоо урсах Монголын их амар амгалан Хөх хөх аргалын дөл Монголын их амар амгалан Хөсөг нүүдэл Монголын их амар амгалан Тооноор туссан наран дотор хүү мөлхөх Монголын их амар амгалан”** хэмээн уншиж, сэтгэл догдолж хөөрөх, ухаарч мэдрэх азтай цагийн уншигчид юм аа бид.

Хүн судлал яруу найрагч эгшиглэдэг, хөрст алтан дэлхийд хүний заяаг олж төрсөн учир утгаа эргэцүүлэн бодлогоширч бичсэн Б.Явуухулан найрагчийн мөрүүд монгол хүмүүн биднийг төрсөн цагаас эхлээд насжих тусам ухааруулах увдистай байжээ.

**“Алтан дэлхийд төрсөн минь учиртай Аавын гэрийн амар тайвныг эвдээд би Ачит эхээ арван сар зовоосны эцэст Алаг үр нь болж баярлуулах гэсэн юм би ... Тохойн чинээ үрийнхээ шөнийн уйлахыг сонсож Төрсөн эцгийнээ авчирсан зовлон, баяр хоёрыг Тоо ёсоор нь өөрөө амсаж мэдэх гэсэн ...”** найрагч **Хүлгийн зоо болсон төрсөн нутагтаа амьдрах гэж Хүүгийн сэтгэлээр эх орондоо хайртай байсан юм гэж Хойч үеэрээ ам бардан хэлүүлэх гэж Хөрст дэлхийд төрснийхөө”** учир утгыг тайлж, сэтгэлээ нээжээ.

Үзэгнийх нь үзүүрээс бичигдсэн шүлэг бүр биднээс өөрийгөө эргэцүүлэн бодож, ухаарах сэдэл санаа өгч байдаг орчин цагийн том зохиолч Д.Урианхайн “Өөрийн тодотгол” хэмээх мөчлөг шүлгүүдийг өрөө тасалгаагаа түгжиж байгаад чив чимээгүйд уншмаар санагддаг юм.

**Өөрийн минь тодотгол: Биеийн зорилго үүрэхдээ бух мэт гүжир зүтгүү амгалант Хэлийн минь тодотгол: Зовлон үмхэхдээ загас мэт дуугай зөнгөөр амгалант Сэтгэлийн минь тодотгол: Золионд үйхдээ хонь мэт номхон хоргүй амгалант Бодохуйн минь тодотгол: Угтын гүнд улайран шунах уйгагүй амгалант Үйлдэхуйн минь тодотгол: Тусын ихэд тухлан шунах туйлгүй амгалант Би-Шивнэрсэн булаг дээгүүр алхаж гардаггүй тойрч гардаг алжаал үгүй амгалант Би-Шивнэрсэн судрын үг давхиж уншдаггүй гэлдэрч уншдаг цөхрөл үгүй амгалант Би-Амьдад ач сэтгэхийн цагт харам үгүй баян амгалант Би-Амьсгалын тоо гүйцэхийн**

**цагт харуусал үгүй, бардам амгалант!** гэсэн богинохон боловч урт ухааны шүлгээ уншигч бидэнд өргөн барьжээ.

Үнэн үг хэлж, үйлс ажил минь шударга шулуун байсныхаа төлөө эргэн тойрондоо адлагдаж, ганцаардах эрсдэл бүхий цагийн хүүхдүүд бидэнд Төрийн шагналт, билигт яруу найрагч О.Дашбалбар хэдхэн жилийн өмнө ийм нэгэн шүлэг бичиж үлдээсэн юм.

**“Олз омог чамд үүдээ хаасан ч тэнгэр шиг бай Олон түмэн нүүрээ буруулсан ч тэнгэр шиг бай Одод гялалзаж, наран саран ээлжлэх цагт Орчлон дээр аавын хүү шантрах ёсгүй Уур омог урин мунхгийг мартаж тэнгэр шиг бай Уйтан хорвоогоос илүү гарч жигүүрээ дэлгэ ... Цохолж ирэх үйлийн үрээс бүү зугт, бүү ай Хувь заяатай ямагт эвлэрч, тэвчээртэй бай ... Жамаараа ертөнцөд юм бүхэн өдөр шөнө шиг ээлжилнэ Жаргал зовлонгийн алинд ч мөнх тэнгэр шиг бай ... Хүсэл бүхэн биелэх албагүй чандалж хорь Хүрэхийн эцэсгүй тэнгэр шиг бай, үнэнийг тэмтэр”** хэмээн тэнүүн орчлонгийн энгээр сэтгэдэг, тэнгэр шиг уужим сэтгэлтэй монгол хүний билгүүн ухааны уриа дуудлага болсон мөрүүдийг хэлжээ.

**ЦАЛГИСАН ХАЙР СЭТГЭЛЭЭР АМЬСГАЛСАН МОНГОЛ НАЙРАГ “Сумын наадмын дэвжээг өдөржин тойрох морьтноос Суран жолоо атгасан өнгийн цэцэг ургаа юу ... Дурлал гээч нь намайг бас л дахин жаргахаар Дугараг цагаан царайгаар наран дороос мишээв үү ... Хайр гээч нь намайг бас л дахин жаргахаар Хайлган цайлган сэтгэлтэй хүний үртэй учруулав уу”** гэж Д.Пүрэвдорж найрагч эрчүүд биднийг төлөөлөн өөрөөсөө асуух мэт шүлэглэж байхад суут яруу найрагч Б.Явуухулан монгол эмэгтэйн цэвэр ичимтгийн зан аалийг зураглаж, бүсгүй хүний хараа булааж сэтгэл татсан эрчүүдийн омог бардам эршүүд үнэн сэтгэлийг

**“Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрэнд Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд Санан санан уярах цэвэр ичимтгий ашинд Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би”** гэж бүсгүй хүнийг хайрлан энэрэх эр хүний заяамал сэрэл, мэдрэмжийг дахин дахин уншмаар гайхам уран дүрсэлж,

**“Цэлмэг үдшийн тэнгэр болох минь ч яалаа даа Чин сэтгэлийн амрагаа би тэргэл сар болгоод Цэнхэр номин уудамдаа цэнгүүлж жаргуулж баярлуулах сан Цэлмэг үдшийн тэнгэр болох минь ч яалаа даа”** гэж халуун зүрхнийхээ мөрөөдлийг бичиглэсэн юм. Бүсгүй хүнийг хайрлаж энэрэх дотор сэтгэлийн илч, гэрлээрээ монгол эр хүн магад ч үгүй бусад улс угсаатнаас ялгарч цолгордог байсан байж болох юм.

Ардын уран зохиолч Б.Лхавгасүрэнгийн **“Миний чамд хайртай минь үнэн Хур нар хоёрт хат суусан Эрмэг хэцийн чулуу шиг үнэн ... Уулс гаднаасаа бууралтаж Дотроосоо ургадаг шиг үнэн Уд урссаар хөлдөж Урсаж гэсдэг шиг үнэн Өнгө сүүдэр ээлжилсэн ертөнцийн Өдөр шөнө хоёр шиг үнэн Дэлхий тэнхлэгээ эргэх шиг үнэн Дээд шаргал нараа дагах шиг үнэн”** хэмээсэн “Хайрын батлан даалт” шүлгээс монгол эр хүний үнэн хайрын тангараг уншигдаж, сэтгэлийн илч гэрэл төөнөдөг. Эрт цагтаа дэлхийн талыг эзэлж, эдүгээ цагийн 100 дөхсөн түүхтэй, эр зориг, авхаалж самбаа, тэсвэр хатуужил, байлдах ур чадвараар энхийг сахиулж танигдаад байгаа өнөөгийн монгол цэрэг яруу найргийн сонгодгуудыг шилэн уншиж, гоо сайхны цэнгэл эдлэн, оюун сэтгэлээ ариусгаж байх тэнгэр заяатай ажгуу.

Зохиолч Г.Аюурзана, уран зохиолын шинжээч Д.Гүн-Уйлс нарын эмхэтгэж хэвлүүлсэн “Монголын сонгомол яруу найраг. УБ.2005”, “Есөн зууны сонгодог бадгууд. УБ. 2017” номуудыг ашиглаж хэвлэлд бэлтгэсэн философийн ухааны доктор, профессор Б.ГАЛИНДЭВ

# САНСАР, ОД ЭРХСЭЭР АЯЛАХЫГ ХҮСВЭЛ ...

1981 оны 3 дугаар сарын 22-ны өдөр бол монгол түмний хувьд хэзээ ч мартагдахааргүй түүхэн өдөр билээ. Энэ өдөр Монгол Улсын сансрын нисгэгч, БНМАУ, ЗХУ-ын баатар, чөлөөнд байгаа хошууч генерал Ж.Гүррагчаа "Союз-39" хөлгөөр сансарт хөөрч, "Салют-6" сансрын станцтай холбогдон долоо хоног, 20 цаг, 42 минутыг өнгөрүүлэн дэлхийг 124 удаа тойрсны дараа эх дэлхийдээ амжилттай газардсан юм.

Нэг удаа 12 дугаар ангийн сурагчаас "Монгол хүн хэдэн онд сансарт ниссэн бэ?" гэж асуухад "Мэдэхгүй" гэж хариулсан. Мэдээж би өнөөдөр өсвөр насны хүүхдүүдийн хэдэн хувь нь монгол хүн сансарт ниссэн тухай мэдэж байгааг хэлж чадахгүй. Ямартаа ч өнөөдрийн залуу үе маань ХХ зуунд тохиосон монголчуудын түүхэн үйл явдлын талаарх мэдээ, мэдээллийг төдийлөн сонирхохгүй байна гэж бодох болов. Тиймээс энэ талын түүх, мэдлэг, мэдээллийг байнга түгээн дэлгэрүүлдэг нэгэн байгууллагад очиж уншигчдад мэдээлэл хүргэхийн хамт үйл ажиллагааг нь сурталчилъя гэж бодлоо. Энэ бол Баянзүрх дүүргийн тавдугаар хороонд буюу Г.К.Жуковын музейн хойно байрладаг Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Хубилай хааны нэрэмжит Сансар, од эрхсийн хүрээлэн /Астропарк/ юм.


Тус хүрээлэн нь сансар судлал буюу космологийн шинжлэх ухааны мэдээ, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд, залуус энэ талын мэдлэг, мэдээллийн ач тус, нийгэмд эзлэх байр суурь, ач холбогдлыг ойлгуулах, соён гэгээрүүлэх үндсэн үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн бус байгууллага ажээ. Сансрын нисгэгч Ж.Гүррагчаа Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн төвтэй хамтран санаачилж энэхүү ордонд босгосон бөгөөд 2014 оны 6 дугаар сарын 1-ний өдөр нээлтээ хийж байжээ. Астропарк нь Сансар танхим, 3D танхим, Оддын театр гэсэн гурван хэсгээс бүрддэг. Сансар танхимын үүдээр орох төдийд л тэр чигээрээ сансрын хөлөгт суусан мэт мэдрэмжийг төрүүлэх бөгөөд хаалганыхаа дугаараас эхлээд л монгол хүн сансарт ниссэн түүхийг өгүүлэх мэт. Хаалга нь 101 гэсэн /Ж.Гүррагчаа нь дэлхийн 101 дэх, Ази тивийн хоёр дахь сансрын нисгэгч юм/ тооттой байх



ажээ. Сансар танхимын эхний хэсэгт 1957 онд анхны хиймэл дагуулыг сансарт хөөргөсөн "Спутник" пуужингаас эхлээд Оросын сансрын пуужингуудын хөгжлийг харуулсан макет байх юм. Түүний дээр хүн төрөлхтний сансар судлалд эргэлт хийсэн дэлхийн алдартай эрдэмтдийн зургийг байгуулсан гавьяатай нь бичжээ. Тэр дундаа Галилео Галилей, Николай Коперник, Исаак Ньютон, Алберт Эйнштейн зэрэг эрдэмтэдтэй хамт Хубилай хаан байх нь нүдэнд ихэд содон харагдана. Энэ талаар тус ордны эрдэм шинжилгээний ажилтан Ч.Амаржаргал тайлбарлахдаа "Бээжингийн Одон орон судалгааны төв гэж сансар, од эрхсийн судлалаар Азидаа гэлтгүй дэлхийд дээгүүрт ордог байгууллага бий. Тус байгууллагыг анх Хубилай хаан Юань улсын идэвхэн мандалтын үед байгуулсан бөгөөд тухайн үедээ 28 мужийн хамгийн шилдэг одон оронч, зурхайчдыг цуглуулан өндөр цалин, пүнлүү өгч, судалгаа, шинжилгээ хийлгэж байсан түүхтэй. Иймээс манай

байгууллага нь Хубилай хааны нэрэмжит болсон юм" гэв.

Цааш явбал хүн төрөлхтний анхны сансрын нисгэгч Ю.Гагаринаас эхлээд үе үеийн сансрын нисгэгчдийн байгуулсан гавьяа, түүхийг харуулсан зурагт самбар байх аж. Тэдгээр зураг дунд 1965 онд "Восход-2" хөлгөөс анх задгай сансарт гарсан А.А.Леоновоос эхлээд "Союз-19" хөлгөөр дэлхийг хамгийн олон удаа тойрсон Казахстаны сансрын нисгэгч Малеченко Мусабеевын



амжилтын талаар өгүүлжээ. Сонирхуулахад тэр бээр 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нисэж, дэлхийг 1993 удаа бүтэн тойрч, 125 хоног, 22 цаг сансарт ажиллажээ.

Сансар танхимын хамгийн үнэтэй үзмэр нь Ж.Гүррагчаа, В.Жанибеков нарын эх дэлхийдээ газардсан "Союз-39" хөлгийн буугч аппарат байлаа. "Союз-39" хөлгийн хүн байрлах хэсэг



нь 8 метр урт бөгөөд түүний гол хэсэгт нь энэхүү буугч аппарат байрладаг байжээ. Их бие болон гадаргууг хөнгөн цагаан, хайлш, цэвэр ган төмрөөр хийсэн бөгөөд гадаргууг нь 2000 хэмийн халуунд тэсвэртэй тусгай материалаар бүрсэн аж. 210 см өндөр, 220 см өргөн, 2900 килограмм жинтэй, капсул хэлбэртэй уг аппарат нь анх 1981 оны 5 дугаар сарын 5-ны өдөр манай улсад ирсэн бөгөөд өмнө нь Тээврийн музейд олон жил хадгалагджээ. Дараа нь тус музейг хаагдахад Ж.Гүррагчаа авч, зуслангийнхаа байшинд 10 гаруй жил хадгалсны эцэст энэхүү ордонд нээгдэхэд хүлээлгэн өгсөн байна. Үнэхээр л явж, явж, байх ёстой газраа ирсэн гэж хэлмээр. Тус ордонд сансрын нисгэгч В.Жанибеков гурван удаа зочилсон бөгөөд сүүлд ирэхдээ хажуу бөөрөн дээр нь тэртээ 1981 онд шохойгоор бичиж байсан "Спасибо" гэсэн үгээ дахин тодруулж дурсгал болгон үлдээсэн гэнэ. Бас нэгэн содон үзмэр нь "Союз-39" хөлгөөр хөөрөх, буух үед сансрын нисгэгчийн өмсдөг скафандр



буюу сансрын нисгэгчийн өмсгөл байлаа. Тус хувцасны дундаж үнэ нь ойролцоогоор 1,5 сая ам.доллар бөгөөд зөвхөн "А" хуулбар нь гэхэд 10 гаруй сая төгрөгийн үнэтэй байдаг гэнэ. Харин энэхүү хувцсыг тус музейн эрдэм шинжилгээний ажилтан Ч.Амаржаргал урласан бөгөөд бодит байдалтай нь тун ойртуулж хийсэн байна. Тус өмсгөлийг

резин шингээсэн даавуугаар хийдэг байна. Задгай сансарт дэлхийн нартай, сүүдэртэй талаас хамаарч хэдэн зуун хэмийн халуун, хүйтний ялгаа гардаг. Тиймээс температурын болон нарны хэт ягаан туяанаас хүний биеийг хамгаалах нь энэхүү хувцасны гол үүрэг юм. Мөн хажуу талдаа хүчилтөрөгч, цэвэр ус зэргийг хүний бие рүү шахдаг тусгай хоолойгоор тоноглогдсон байдаг ажээ.

Дараагийн хэсэгт зөвхөн сансрын нисгэгчдэд зориулан



олгодог медаль, тэмдгүүдийг байрлуулсан байв. Тэр дунд зөвхөн "Союз" сансрын хөлгөөр ниссэн хүмүүст олгодог В.М.Камаровын алтан медаль ч байх юм. В.М.Камаров нь сансарт хоёр удаа ниссэн дэлхийн хамгийн анхны хүн. Анх 1964 онд "Восход-1" сансрын хөлгөөр амжилттай ниссэн тэр бээр хоёр дахь удаагаа "Союз-1" хөлгөөр сансарт нисээд эх дэлхийдээ буух замдаа хөлгийн буугч аппаратын шүхэр нь дэлгэгдээгүйгээс харамсалтайгаар амиа алджээ. Тэр бээр сансарт нисээд дэлхийдээ эргэж ирээгүй анхны хүн бөгөөд түүнийг гэгээн дурсгалд зориулан энэхүү медалийг бий болгожээ.

Цааш явбал сансрын нисгэгчдийн гарын үсэгтэй ил захидал, тэдний ууж, иддэг хүнсний бүтээгдэхүүнүүд, одон, медаль, тэмдгүүд шилэн хорго дотор гялалзан харагдана. Тэр дундаас сансрын орчинд ажилладаг үзэг миний анхаарлыг их татсан. Уг үзгийг 1967 оноос



АНУ-д үйлдвэрлэж эхэлсэн ба -40 хэмээс +120 хэмд гардаг. Мөн жингүйдлийн орчинд болон өндөр даралтын үед ч ажилладаг сонирхолтой үзэг байв. Өнөөдөр ч гэсэн тус үзгийг дэлхийн олон орны сансрын нисгэгчид ашигладаг гэнэ. Харин Оддын театрт хүүхэд, залууст одон орон судлалын талаар ойлголт өгөх зорилготой планетариумын танхимыг байгуулжээ. Энэ нь тус ордны бөмбөгөр оройд "Minoleta-MS-8" тусгай төхөөрөмжийн тусламжтайгаар гэрлийн хугарлыг ашиглаж оддыг бий болгодог юм.

Энэ мэт тус ордонд байх үзмэр, танхим бүрийн онцлогийг тайлбарлан бичье гэвэл сонины зай, талбай хүрэлцэхгүй биз ээ. Ямартаа ч Монголын ирээдүй болсон хүүхэд, залуусыг шинжлэх ухаанчаар хүмүүжүүлж, соён гэгээрүүлэх үйлсийг эрхэлж байгаа тус байгууллагын хамт олны гавьяа, зүтгэлийн ачаар энэ бүхэн бий болсон гэдэг нь ойлгомжтой. Аливаа улсын хөгжил нь шинжлэх ухааны салбартаа суурилдаг шүү дээ. Тиймээс Монголын "ирээдүй" шинжлэх ухаанчаар хүмүүжүүлэх ийм төрлийн олон байгууллага бий болоосой гэж хүснэм.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

## Аавгаа бүтэх захидал

"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 99 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн соёл хүмүүжлийн албанаас аавдаа бичих захидал буюу "Би эр цэрэг боллоо" шилдэг захидлын уралдааныг цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулснаас Сонгинохайрхан дүүргээс 2019 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан байлдагч Н.Нямдоржийн захидал тэргүүн байрт шалгарав.



Сайн байна уу? Миний зүрхний бурхан аав Таны минь бие тэнхээ сайн биз дээ. Та минь биднийг өдий зэрэгтэй хүн болгох гэж гадаа гандаж, хөдөө хөхөрч юу эсийг тууллаа даа. Тийм болохоор Та минь биднийгээ шүтээн нь юм шүү дээ. Саяхан л Таныхаа өвөр дээр эрхлэн дүрсгүйтэж явсан бор хүү нь одоо эр цэргийн алба нэр төртэй хааж, Монгол Улсынхаа иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж байгаагаа баяртайгаар хэлэхийн хамт эр цэргийн хуарангаас энэхүү захидлаа бичиж сууна. Хүү нь олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэн Таныхаа нэрийг өндөрт өргөж, цэргийн албыг хаагаад аль хэдийн 10 сарыг ардаа үджээ. Цаг хугацаа ямар хурдан өнгөрнө вэ.

Би холбооны тусгай хороонд алба хааж, аавынхаа үргэлжлэл болсондоо туйлаас баяртай байна. Тэртээ 34 жилийн өмнө Та минь энэ ангид гурван жил цэргийн алба хаасан шүү дээ. Аан бас тийм, дунд ах маань ч бас энд албаа хаасан. Ингээд бодохоор манай гэр бүлийн гурван үеийн эрчүүд Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн жагсаалын талбайгаас эх орны хүү болж, эр цэргийн тангараг өргөжээ.


Таныхаа хүүдээ хэлж, захидаг ухаант сургаалуудыг тань алхам тутамдаа санаж, хэрэгжүүлж явдаг юм шүү, ааваа. Хонгор үрсийнхээ төлөө Та минь эр хүний үүрч болох бүхий л ачааг нуруундаа үүрч, хүнд хэцүү цаг мөчүүдийг даван туулж чадсан. Таны минь зориг тэвчээр, гэр бүлээ гэсэн эр хүний уужим ухааныг хүү тань үргэлж хүндэтгэн биширч, даган дуурайж явдаг юм. Таныгаа маш их санаж байна, надад хийж өгдөг хоолны тань амтыг хүртэл санаж байна. Энэ хорвоогийн хамгийн мундаг тогооч бол Та. Удахгүй дээ аав минь, удахгүй. Хүү нь хоёрхон сарын дараа халагдаад Тандаа очлоо. Таныхаа ачийг хариулахын төлөө улам их хичээж, улс эх орондоо хэрэгтэй сайн хүн болно оо. Ингээд хайрт аавдаа цэргийн баярын мэнд хүргэе.

Сайхан залуу аавынхаа тэргүүнд  
буурал орсныг анх үзээд  
Саваагүй томоогүй хүүхэд насаа  
би тэр жилийн шувуудтай буцаасан  
Санчигт нь нэмэгдэх мөнгөн сарны тоогоор  
Таныгаа хүү нь жаргаана аа  
Сайхан аав тандаа хүү нь  
хязгааргүй их хайртай шүү ...

"Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн байлдагч  
Н.НЯМДОРЖООС хайрт аав Ц.НАРАН-ОЧИРТОО

## ЭМГЭНЭЛ

### ЭРДЭНЭБАТЫН МӨНХЧУЛУУН /1990-2020/



Зэвсэгт хүчний шилдэг инженерүүдийн нэг, радиотехникийн чадварлаг офицер, ахмад Э.Мөнхчулуун нь хүнд өвчний улмаас таалал төгсөж бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Тэр бээр 1990 онд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутагт төрсөн. 1998-2008 онд Мөрөн сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийг дүүргэж, 2008-2013 онд Батлан хамгаалахын их сургуульд суралцаж радиоэлектроникийн инженер, радиотехникийн команд мэргэжлээр төгссөн.

Ахмад Э.Мөнхчулуун нь 2013 оноос хойш Зэвсэгт хүчний 353 дугаар ангид РЛС-ын оператор, салааны захирагч, системийн инженер зэрэг албан тушаалд томилогдон ажиллаж, эх орныхоо өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, улсынхаа агаарын дархан хилийг манах хүндтэй үүргийг мэргэжлийн өндөр түвшинд биелүүлж байсан юм.

Түүний тусч, ажилч, хичээнгүй, хүнлэг сайхан зан чанар, гэгээн дүр нь бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно. Ум сайн амгалан болтугай.

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ,  
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 353 ДУГААР АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН,  
ГЭР БҮЛ, АХАН ДҮҮС, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НӨХӨД НЬ**